



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАЙ
ГАЗАР

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ



2021 он



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Менежментийн төлөвлөлтийн арга
зүйг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүйг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү төлөвлөлтийн арга зүйг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж, ажиллахыг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргаадын дарга нарт даалгасугай.

3. Менежментийн төлөвлөлтийн арга зүйн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар (Ч.Батсансар)-т үүрэг болгосугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
1/16 дугаар/дүгээр тушаалын хавсралт

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй

Арга зүйг сайжруулан боловсруулсан багийн гишүүд:

- Б. Мөнхчулуун – Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар
- Э. Төгөлдөр – Дэ Нэйчэ консерванси (TNC), Монгол дахь төлөөлөгчийн газар
- Г. Энхмөнх – Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Д. Галбадрах – Дэ Нэйчэ консерванси (TNC), Монгол дахь төлөөлөгчийн газар
- П. Галрагчаа – Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл
- Т. Болдбаатар – Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар
- Б. Энхгэрэл – Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар

Хянасан:

- Ч. Батсансар – Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын дарга

ГАРЧИГ

Товчилсон үгийн тайлбар	4
Арга зүйн талаар	5
Үндэслэл	6
Менежментийн төлөвлөлт хийхэд баримтлах зарчим	8
Менежментийн төлөвлөгөөний ач холбогдол	10
Менежментийн төлөвлөгөө боловсруулахад тавигдах шаардлага	11
1. ТОДОРХОЙЛОХ	13
1.1 Төлөвлөлтийн зорилго, ажлын хэсэг	14
1.2 Хамрах хүрээ, алсын хараа	18
1.3 Хамгаалах үнэт зүйлс	21
1.4 Аюул, дарамт	27
1.5 Нөхцөл байдлын дүн шинжилгээ	37
2. ТӨЛӨВЛӨХ	40
2.1 Зорилго, стратеги, зорилт	40
2.2 Үйл ажиллагааны төлөвлөгөө	52
2.3 Мониторингийн төлөвлөгөө	53
3. ХЭРЭГЖҮҮЛЭХ	57
3.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөө	58
3.2 Хүний нөөцийн чадавхи бэхжүүлэх	59
3.3 Төсөв, санхүүжилт	61
4. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, УЯЛДУУЛАХ	63
4.1 Мэдээллийн сан	65
4.2 Үр дүнг үнэлэх	68
4.3 Төлөвлөгөөг уялдуулах	74
5. ҮР ДҮНГ ХУВААЛЦАХ	75
5.1 Үр дүн, амжилт, сургамж	76
5.2 Оролцогч талуудад мэдээлэл түгээх, солилцох	77
Ашигласан бүтээлийн жагсаалт	78
Хавсралт 1. Менежментийн төлөвлөгөөний үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд	79
Хавсралт 2: Төлөвлөлттэй холбоотой нэмэлт мэдээллийн эх сурвалж	80

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БНГ	- Байгалийн нөөц газар
БОАЖЯ	- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЯ	- Байгаль орчны яам
БЦГ	- Байгалийн цогцолборт газар
ДБХС	- Дэлхийн байгаль хамгаалах сан
ДГ	- Дурсгалт газар
ДЦГ	- Дархан цаазат газар
НҮБ	- Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБХХ	- Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ТББ	- Төрийн бус байгууллага
ТХГН	- Тусгай хамгаалалттай газар нутаг
УИХ	- Улсын Их хурал
ЭЧХЗ	- Экологийн чухал хүчин зүйл
СВД	- Convention on Biological Diversity
IUCN	- International Union for Conservation of Nature
GEF	- Global Environment Facility
GIZ	- Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit
МАВ	- Man and Biodiversity
METT	- Management effectiveness tracking tool
TNC	- The Nature Conservancy
UNEP	- United Nations Environment Programme
UNDP	- United Nations Development Programme
WWF	- World wildlife fund for Nature



Зөвшөөрлөөр арга зүйн логог ашиглав.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн дэмжлэгтэйгээр бэлтгэн хэвлэв.

АРГА ЗҮЙН ТАЛААР

Тусгай хамгаалалттай газар нутагт үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх олон арга зам бий. Түүний нэг нь менежментэд ашиглаж буй арга аргачлалыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал юм. БОАЖЯ-ы Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газраас энэ талаар анхааран менежментийн төлөвлөлтийн арга зүйг шинэчлэн гаргаж байна.

Энэхүү арга зүйн давуу, шинэлэг талууд нь:

- ✓ Менежментийн цогц төлөвлөлт хийхэд чиглүүлсэн;
- ✓ Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12-р сарын 31-ны өдрийн тушаалаар батлагдсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалтай уялдуулж нийцүүлсэн;
- ✓ Олон улсад өргөнөөр ашиглаж буй Conservation standard арга зүйн сүүлийн хувилбар (2020 он)-ын шинэлэг санаачилгуудыг тусгасан;
- ✓ 2010 оноос хойш Монгол улсын хэмжээнд нийт 73 тусгай хамгаалалттай газар нутаг Open/conservation standard арга зүйгээр менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Энэ чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөрүүд хамтран ажиллаж мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг сурган чадавхижуулж ирсэн ба ийнхүү хуримтлуулсан туршлага дээрээ суурилсан санаачилгуудыг багтаасан;
- ✓ Тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль хамгааллын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн уур амьсгалын өөрчлөлт, хүний сайн сайхны төлөөх зорилт, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах механизм зэрэг шинэлэг санаачилгыг тусгах зөвлөмж, зааврыг оруулж өгсөн.

Үр дүнд суурилсан, дасан зохицох менежментийн зарчимд нийцсэн, талуудын оролцоонд тулгуурласан энэхүү менежментийн төлөвлөлтийн арга зүй нь Монгол улсын ТХГН-уудын менежментийн үр нөлөөг сайжруулах хөгжлийн хөтөч болох юм.

*БОАЖЯ-ы Тусгай хамгаалалттай бүс нутгийн
удирдлагын газрын дарга Ч.Батсансар*

ҮНДЭСЛЭЛ

1992 онд зохион байгуулагдсан НҮБ-ын “Байгаль орчин ба Хөгжил” сэдэвт Бага хуралд Монгол улс тогтвортой хөгжлийн анхны илтгэлээ танилцуулж газар нутгийнхаа 30-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах нэн чухал санаачлагыг дэвшүүлсэн бөгөөд энэ нь төрийн дараах бодлогын баримт бичгүүдэд тусаж ирсэн. Үүнд:

- Биологийн төрөл зүйлийн үндэсний хөтөлбөр (1996);
- Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998);
- Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1998);
- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2008);
- Ус үндэсний хөтөлбөр (2010);
- Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010);
- Нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний хөтөлбөр (2011);
- Ногоон хөгжлийн бодлого (2014);
- Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025), (2015);
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030 (2016)
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020).

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд 2020 оны байдлаар Монгол улс нийт нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 32.7 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулаад байна.

Монгол улс тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээгээ өргөжүүлэхийн зэрэгцээгээр түүний менежментийг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх зорилтыг дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулсан үндэслэл, дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлсон менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг олон улсын практик 1960-аад оноос эхтэй бөгөөд эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн арга хэрэгсэл болжээ.

1998 онд Монгол Улсын Их Хурлаас батлагдан гарсан Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрт тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) бүр өөрийн үйл ажиллагааны урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээр заасан. ТХГН-уудаас хамгийн анхны менежментийн төлөвлөгөөг 1998 онд Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар (БЦГ)-ын хамгаалалтын захиргаа боловсруулж Байгаль орчны яам (БОЯ)-аар батлуулсан байдаг.

Монгол улсад ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах анхны заавар, зөвлөмжийг 2007 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Даян дэлхийн байгаль орчны сан (Global Environment Facility - GEF)-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах ба тогтвортой хөгжлийн арга зам” төслийн хүрээнд БОЯ, Тусгай хамгаалалттай нутгийн Удирдлагын газар (ТХНУГ)-аас гаргасан байдаг. Ингэхдээ Дэлхийн байгаль хамгаалах холбоо (International Union for Conservation of Nature - IUCN)-ноос гаргасан аргачилсан зөвлөмж, зааврыг ерөнхийд нь баримтлан Монгол орны нөхцөлд уялдуулан боловсруулсан. Үүний дараа 2012 онд НҮБХХ, ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх төслийн дэмжлэгтэйгээр ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийг шинэчлэн гаргасан. Тус зөвлөмжид байгаль хамгааллын төлөвлөлтийн Нээлттэй Стандарт (Open/Conservation standard <https://cmp-openstandards.org/>) арга зүйн үндсэн зарчмыг тусган өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулсан. Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт (Нээлттэй стандарт) нь дасан зохицох менежмент (Adaptive management), үр дүнд суурилсан менежмент (Result based management)-ийн зарчмууд, энэ чиглэлээрх дэлхийн хэмжээний шилдэг, тэргүүн туршлагауудыг нэгтгэсэн, практикт суурилсан арга зүй учраас олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч өргөн ашиглагдаж байна. Монгол улсад байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд 2006 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд одоогоор улсын хэмжээнд 60 гаруй ТХГН 2012 онд гаргасан зөвлөмжийн дагуу менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Энэхүү гурав дахь арга зүйг Монгол улсын Засгийн газраас бодлого төлөвлөлтийн чиглэлээр гаргасан журам, арга зүйн заавар, зөвлөмжийг баримтлан, Байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйн үндсэн зарчимд суурилан, Монгол орны ТХГН-ууд төдийгүй олон улсын хэмжээнд хуримтлуулсан туршлагад үндэслэн холбогдох мэдээлэл, жишээгээр баяжуулж сайжруулан гаргаж байна.

Арга зүйг 2020 онд Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас батлан гаргасан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд туссан нийтлэг шаардлагуудтай бүрэн уялдуулахын зэрэгцээ тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулсан үндэслэл, экосистем, биологийн олон байдал, байгаль хамгааллын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн илүү нарийвчилан, холбогдох зөвлөмж, зааврыг тусгаж өгсөнөөрөө давуу талтай болсон. Уялдааг хангахдаа бүх агуулгыг давхцуулахгүй байх зарчим барьсан тул энэхүү арга зүйг дээрх “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-тай хослуулан ашиглах нь зүйтэй.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө гэдэг нь тухайн тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулсан зорилгыг хэрэгжүүлэхэд өнөө ба ирээдүйд баримтлах бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон хөгжлийн хөтөч болох үндсэн баримт бичиг байна. Нөгөө талаас менежментийн төлөвлөгөө нь аливаа үйл ажиллагааг төлөвлөөд орхидог дан ганц үйл явц биш бөгөөд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, түүний үр дүнд үндэслэн төлөвлөлтийг сайжруулах; энэ хугацаанд хуримтлуулсан амжилт, сургамжаа бусадтай хуваалцах гэсэн уян хатан, эргэлттэй бүхэл бүтэн процесс байдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь нэг загварын хэвшмэл, зогсонги үйл явц биш бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөгдөж, сайжирч байдаг үйл явц юм.

ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

1
*Хөгжлийн бодлого,
төлөвлөгөөтэй
харилцан
уялдаатай,
бодлогын залгамж
чанарыг хадгалсан
байх*

Монгол улсын олон улсын хэмжээнд нэгдэн орсон конвенци, бусад эрх зүйн актууд, Үндэсний бодлого, байгаль орчны болон ТХГН-ийн талаарх дүрэм журмууд, бүс нутаг ба орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй нийцсэн байх нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чухал нөлөөтэй. Нөгөө талаас тухайн ТХГН-ийн хамгааллын менежментийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж бүс нутаг, орон нутгийн хөгжлийн болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, харилцан уялдуулж төлөвлөх нь менежментийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа өмнөх төлөвлөгөөний алсын хараа, дэвшүүлсэн зорилго, зорилт, тэдгээрийн хэрэгжилт, амжилт сургамжийг тусган анхаарах нь тухайн ТХГН-ийн байгуулсан зорилгын хүрээнд үйл ажиллагааны залгамж холбоог хангах ач холбогдолтой.

2
*Хамтын оролцоог
хангах, ил тод,
нээлттэй байх:*

Талуудын оролцоог төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, шийдвэр гаргах гэсэн бүхий л шатанд хангаснаар ил тод, нээлттэй байж тэдний санаа бодлыг тусгах, ойлголтыг нэгтгэх, улмаар үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж, үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Иймээс төлөвлөгөө боловсруулж эхлэхдээ менежментийн бүхий л үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн үүрэг оролцоо, түвшинг тодорхойлж, төлөвлөлтийн бүх үе шатанд оролцоог хангах.

3
Түншлэх:

Нэг байгууллага төлөвлөгөөнд туссан шаардлагатай бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод нөөц боломж, туршлага хангалтгүй, хязгаарлагдмал байж болох юм. Тиймээс, байгууллагуудтай албан ба албан бус харилцаа холбоо тогтоох байдлаар түншлэл бий болгон тогтвортойгоор хамтран ажиллах нь хамгааллын менежментийн үр дүнг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Ялангуяа Монгол орны хувьд газар нутаг том, хамгаалалтын захиргааны ажилтны хүртээмж, хангамж бололцоо бага энэ нөхцөлд тухайн газарт байгалийн нөөцийг ашиглаж буй эсвэл үйл ажиллагааны чиглэл, сонирхол ижил байгууллагуудтай албан ёсоор гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах замаар хамтын

ажиллагаагаа баталгаажуулах нь зүйтэй. Энэ нь үйл ажиллагааг өргөжүүлэх, үр дүнг тогтвортой хадгалан үлдэх үндэс болно.

4
**Бүгдийг бус
чухлыг сонгох:**

Тухайн газар нутаг дээрх бүхий л байгалийн нөөц баялаг, экосистем, биологийн төрөл зүйлийг хамгаалах боломж хомс бөгөөд хөрөнгө, цаг хугацаа, хүн хүч ихээр шаарддаг төдийгүй бүх зүйлд нэгэн зэрэг төвлөрөх нь үйл ажиллагааны үр дүнг бууруулах нэг шалтгаан болдог. Иймээс бүгдийг бус чухлыг гэсэн зарчмыг баримтлах нь зүйтэй. Энэ нь байгаль хамгааллын төлөвлөлтийн стандарт арга зүйн үндсэн зарчмын нэг бөгөөд тухайн газар дээрх экосистем, биологийн төрөл зүйл, байгалийн нөөц баялгийг нийтэд нь бус тухайн газар нутгийн онцлогийг илэрхийлж чадахуйц тодорхой тооны, голлон хамгаалах үнэт зүйлийг төлөөлөл (түүгээр дамжуулан бүгдийг хамгаалах гэсэн утга) болгож сонгон хамгаалах нь үйл ажиллагааг маш тодорхой, оновчтой чиглүүлж өгдөгөөрөө ач холбогдолтой. Энэ зарчмыг зөвхөн хамгаалах үнэт зүйлийг сонгоход бус аюул, дарамт, хамгааллын стратегийг тэргүүлэх байдлаар нь үнэлж эрэмбэлэх зэрэг төлөвлөгөө боловсруулах алхам бүрт баримтлах нь зүйтэй.

5
**Бодит мэдээлэлд
суурилах, нотлох
баримт бүрдүүлж
зохих ёсоор
ашиглах:**

Менежментийн төлөвлөгөө боловсруулах, үр дүнг үнэлж дүгнэхдээ судалгаа шинжилгээний бодит мэдээлэл, нотлох баримтад суурилна. Ингэхдээ тухайн ТХГН, орон нутаг, улсын хэмжээний болон дэлхийн хэмжээнд байгаа боломжит мэдээлэл, нотолгоог ашиглах хэрэгтэй. Мэдээллийн сан хараахан бүрдээгүй тохиолдолд хамтрагч талуудын оролцоотойгоор анхан шатны мэдээлэл цуглуулан үнэлгээ, дүн шинжилгээ хийх ба цаашид шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх талаар төлөвлөлтөдөө тусган ажиллана. Арга зүйн зарчмын дагуу бүх бус чухал мэдээллийг цуглуулахад анхаарах хэрэгтэй. Энэ нь төсөв, цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой.

6
**Үр дүнгээ
тогтмол хянах:**

Үйл ажиллагааны үр дүнгээ тогтмол хянаж байх нь менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулан, төлөвлөлтийг улам боловсронгуй болгоход тустай байдаг. Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг жил бүр талуудын оролцоотойгоор хэлэлцэж байх нь зүйтэй бөгөөд энэ нь талуудын оролцоог нэмэгдүүлэх арга хэлбэр болдог.

7
Уян хатан байх

Шаардлагатай тохиолдолд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад бий болсон нөхцөл байдал, үр дүнтэй уялдуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга, хэлбэрээ өөрчлөх эсвэл төлөвлөгөөг талуудын оролцоотой дахин хэлэлцэн сайжруулах, хэсэгчлэн өөрчлөх эсвэл бүр шинэчлэн боловсруулах шийдвэрийг хамтын оролцоотойгоор гаргаж болно. Энэ нь дасан зохицох менежментийн арга зүйн гол зарчим юм. Гагцхүү энэ нь бодит үнэлгээ, түүний дүгнэлтэд үндэслэх учиртай бөгөөд ялангуяа менежментийг хэрэгжүүлэгчид аливаа өөрчлөлтөд бэлэн байж хамтрагч, оролцогч, сонирхогч талуудаа уриалдаг байх ёстой.

8

*Туршлагаа
хуваалцах,
суралцах,
нээлттэй
харилцах:*

Менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн бүх шатанд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд амжилт, сургамж байнга гарч байдаг. Энэ бүхнийг зөвхөн өөртөө хадгалан үлдэх бус бусадтай олон арга замаар хуваалцдаг байх ёстой. Энэ нь хамтрагч, оролцогч болон сонирхогч талуудын анхаарлыг татаж, оролцоог нэмэгдүүлэхээс гадна менежментийг хэрэгжүүлэгчид өөрсдөө алдаа оноо, сургамжаа ойлгон төлөвлөлтөө сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

- ТХГН-ийн талаархи бодит мэдээлэл дээр суурилагдсан байх тул түүний үнэ цэнэ, нөөцийг бүрэн тооцож, байгуулсан зорилгоо хэрэгжүүлэхэд менежментийн оновчтой шийдэл олох боломжийг олгодог.
- Тухайн ТХГН-ийн менежментийн үндсэн бодлогыг тодорхойлохын зэрэгцээ Монгол улсын олон улсын хэмжээнд нэгдэн орсон конвенци, бусад эрх зүйн актууд, Үндэсний бодлого, байгаль орчны болон ТХГН-ийн талаарх дүрэм журмууд, бүс нутаг ба орон нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэгт нийцсэн байх тул хөгжлийн бодлогын уялдаа холбоо, хэрэгжилтийг хангах чухал баримт бичиг болдог.
- Менежментийг хариуцагчийн өдөр тутмын болон дунд, урт хугацааны үйл ажиллагааны удирдамж болохын хувьд алсын хараа, зорилго, зорилт, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд тусалдаг.
- ТХГН-ийн зорилгын хүрээнд менежментийн залгамж чанар, тасралтгүй байдлыг хангаж өгдөг.
- Байгаль хамгааллын ажлын үр дүн, менежментийг хариуцагч байгууллагын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг тодорхойлж, дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байдалдаа үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгодог.
- ТХГН-ийн удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог оновчтой төлөвлөх, улмаар хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагчдыг чадавхижуулах, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх хэрэгсэл буюу байгууллагын хүний нөөцийн хөгжлийн гол түлхүүр, суурь болно.
- Санхүү, материаллаг баазын зохистой төлөвлөлт хийх, хөрөнгийг зөв төлөвлөж зарцуулах, хяналт тавих боломж олгодог.
- ТХГН-ийн менежментэд оролцогч талууд болох хамгаалалтын захиргаа, нутгийн иргэд, шийдвэр гаргагчдын хамтын ажиллагаанд холбогч гүүр нь болдог.
- ТХГН-ийн талаархи олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг бий болгон хамтын менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.
- ТХГН-ийн менежментэд олон улсын байгууллага, хандивлагчдыг татан оролцуулах, санхүүгийн эх үүсвэрийг олоход тусалдаг.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Менежментийн төлөвлөгөө боловсруулахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- Тухайн ТХГН-ийг байгуулсан үндэслэл, зорилгын хэрэгжилтийг хангахад чиглэсэн, өөрийн онцлогт нийцсэн байх;
- Үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, байгаль орчны багц хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журам зэрэгт тусгагдсан үзэл баримтлалыг бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн, ТХГН-ийн менежментийн хэрэгцээ шаардлага нь тэдгээр хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан, нийцсэн буюу харилцан уялдсан байх;
- Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенцуудын үзэл санаатай нийцсэн байх,
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, байгаль хамгаалах бүлэг, нөхөрлөл, иргэд, хувийн хэвшлийн оролцоог хангахуйц бүтэц, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг хангасан;
- Экосистем, биологийн олон янз байдал, байгалийн нөөц баялгийг ашиглах, хамгаалах талаар урьд нь хэрэгжиж ирсэн үйл ажиллагаанд үнэлэлт өгч цаашид хийгдэх үйл ажиллагааг уялдуулан оновчтой хувилбарыг сонгон авсан байх;
- Орчны бүс дэх нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагуудтай үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, ландшафт, бүс нутгийн түвшинд байгаль хамгаалал, хөгжлийн нэгдмэл чанарыг хангасан;
- Менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөцийн чадамжийг харгалзсан;
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд уг төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцдаа чадавхижсан, хамтын ажиллагаа нь итгэлцэл, хамтын харилцан хариуцлагад тулгуурласан байх,
- Бодит мэдээлэл, шинжлэх ухааны судалгаа, нотлох баримтад суурилсан байх;
- Менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналтад хамтын оролцооны аргыг гол зарчмаа болгосон байх,
- Дэвшүүлсэн зорилго, зорилт, төлөвлөсөн үйл ажиллагаа нь хэрэгжихүйц, бодитой байх,
- Менежментийн төлөвлөгөө боловсруулахад тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аль болох орчин үеийн шинэлэг, дэвшилтэт технологи, арга зүй ашигласан байна.

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТ

Төлөвлөлт нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнгээ хянаж үнэлэх, үр дүнд үндэслэн төлөвлөгөөг дахин сайжруулах, амжилт, сургамжаа хуваалцах гэсэн уян хатан, эргэлттэй бүхэл бүтэн процесс юм. Энэ нь нэг загварын хэвшмэл, зогсонги үйл явц биш бөгөөд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөгдөж, сайжирч байдаг үйл явц. Менежментийн төлөвлөгөө нь энэхүү бүхэл бүтэн үйл явцыг баримтжуулж албажуулсан баримт бичиг юм.

Төлөвлөлт нь дараах үндсэн үе шат, алхамуудаас бүрдэнэ.

1. ТОДОРХОЙЛОХ

- 1.1 Төлөвлөлтийн зорилго, ажлын хэсэг
- 1.2 Хамрах хүрээ, алсын хараа
- 1.3 Хамгаалах үнэт зүйлс
- 1.4 Аюул, дарамт
- 1.5 Нөхцөл байдлын дүн шинжилгээ

2. ТӨЛӨВЛӨХ

- 2.1 Зорилго, стратеги, зорилт
- 2.2 Үйл ажиллагааны төлөвлөгөө
- 2.3 Мониторингийн төлөвлөгөө



5. ҮР ДҮНГ ХУВААЛЦАХ

- 5.1 Үр дүн, амжилт, сургамж
- 5.2 Оролцогч талуудад мэдээлэл түгээх, солилцох

3. ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 3.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөө
- 3.2 Хүний нөөцийн чадавхи бэхжүүлэх
- 3.3 Төсөв, санхүүжилт

4. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, УЯЛДУУЛАХ

- 4.1 Мэдээллийн сан
- 4.2 Үр дүнг үнэлэх
- 4.3 Төлөвлөгөөг уялдуулах



ТОДОРХОЙЛОХ



ТӨЛӨВЛӨХ



ХЭРЭГЖҮҮЛЭХ



**ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ,
УЯЛДУУЛАХ**



**ҮР ДҮНГ
ХУВААЛЦАХ**





ТОДОРХОЙЛОХ

Менежментийн төлөвлөлтийн хамгийн эхний үе шатанд тухайн ТХГН-ийн экосистем, биологийн олон янз байдал, түүх, соёлын дурсгалын өнөөгийн төлөв, түүний өөрчлөлтийн чиг хандлага, тэдгээрийн хамгааллын менежментийн нөхцөл байдалд талуудын оролцоотойгоор дүн шинжилгээ хийж бид хаана байна, ямар асуудал, ямар боломж байна вэ гэдгийг тодорхойлно. Тодорхойлох үе шат нь дараах алхамуудаас бүрдэнэ. Үүнд:

- 1.1 Төлөвлөлтийн зорилго тодорхойлох, ажлын хэсэг байгуулах
- 1.2 Хамрах хүрээ, алсын харааг тодорхойлох
- 1.3 Хамгаалах үнэт зүйлс, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох
- 1.4 Аюул, дарамтыг тодорхойлж үнэлэх
- 1.5 Хамгааллын менежментийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх

1.1 ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ, АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ

Энэ алхамын хүрээнд ТХГН-ийн менежментийг хариуцагчид өмнөх төлөвлөгөө боловсруулах явц, түүний хэрэгжилтээс гарсан амжилт сургамж, өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хамтаараа хэлэлцэн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн зорилгоо тодорхойлж, төлөвлөгөө гарган албажуулна.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил нь нэг хүний бус, багийн ажил байдаг бөгөөд багийн гишүүдийн нягт хамтын ажиллагааг шаарддаг. Түүнчлэн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх нь зөвхөн менежментийг хариуцагчийн үүрэг, хариуцлага биш бөгөөд олон талт хамтын ажиллагааны үр дүн байдаг. Тиймээс хамгааллын менежментэд талуудын оролцоог хангахын тулд төлөвлөгөө боловсруулахаас эхлэн төлөвлөлтийн бусад бүхий л үе шатанд талуудын оролцоог хангахад анхаарах хэрэгтэй.

Менежментийн төлөвлөгөө боловсруулахаас өмнө тухайн ТХГН-ийн менежментийг хариуцагч нь хамгааллын менежментэд оролцогч талуудаа нэрлэж, хэрэгцээ, нөөц боломжоо харгалзан менежментийн төлөвлөгөө боловсруулахад зайлшгүй оролцох талуудыг сонгон, тэдний оролцох боломжит хэлбэрийг тодорхойлж, түвшинг тогтооно. Ингэхдээ дараах (үүгээр хязгаарлахгүй бөгөөд үзүүлэлт нэмж болно) нөхцөлийг харгалзана. Үүнд:

- Үнэлгээ хийхэд оролцох шаардлагатай;
- Анхан шатны хэлэлцүүлэг хийхэд оролцох шаардлагатай;
- Санал асуулгын хуудсаар санал авах, өгөх боломжтой;
- Албан бичгээр санал авах, өгөх боломжтой;
- Биечилж уулзаж санал, зөвлөмж авах, өгөх боломжтой;
- Эцсийн хэлэлцүүлэгт оролцох шаардлагатай.

Жишээ: Оролцооны хэлбэр, түвшинг тодорхойлж буй байдал

№	Талуудын нэр	Менежментийн төлөвлөгөө боловсруулахад оролцох хэлбэр, боломж						Оролцооны түвшин
		Үнэлгээ хийхэд оролцох	Сумын түвшинд анхан шатны хэлэлцүүлэг хийхэд оролцох	Санал асуулгын хуудсаар санал авах	Албан бичгээр санал авах	Биечилж уулзаж санал, зөвлөмж авах	Эцсийн хэлэлцүүлэгт оролцох	
1	ТХНУГ				+	+		2
2	Сумдын засаг дарга	+	+		+	+	+	5
3	Сумдын ИТХ-ын дарга, гишүүд	+	+		+	+	+	5
4	Сумдын багийн засаг дарга нар	+	+					2
5	Иргэдийн төлөөлөл	+	+	+				3
6	Судлаачид	+	+	+				3
	гэх мэт							

Оролцогч талуудыг сонгохдоо дараах нөхцөлүүдийг харгалзан үзэж болно. Үүнд:

- **Газар зүйн байрлал:** ТХГН, түүний орчны бүсэд амьдардаг нутгийн иргэд болон түр оршин суугчид;
- **ТХГН-ийг ашиглах байдал:** ТХГН-т үйл ажиллагаа явуулж бизнес эрхлэх зорилгоор аялал жуулчлал эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд, эко гэр ажиллуулагчид, түүх, соёлын үнэт зүйл ашиглагчид зэрэг хуулийн хүрээнд газар, түүх соёл, байгалийн нөөц ашиглагчид;
- **ТХГН-ийн хамгаалах үнэт зүйлсэд үзүүлэх нөлөөлөл:** Хамгаалах үнэт зүйлсэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж байгаа болон болзошгүй бүлгийн төлөөлөл;
- **Үндэстэн, ястны ялгаатай байдал:** Тухайн орон нутагт амьдарч байгаа үндэсний цөөнх, шашин шүтлэгийн ялгаа, нутгийн уугуул иргэдийн төлөөллийг харгалзах;
- **Хүйсийн тэгш байдлыг хангах:** Эрэгтэй, эмэгтэй хүмүүс аливаа асуудлыг өөр өөр өнцгөөс хардаг тул нийгмийн зарим харилцаанд хүйсийн тэнцвэрт байдал чухал үүрэгтэй;
- **Эрхэлж буй ажил:** Төрийн албан хаагч, менежер, газар ашиглагч, уламжлалт аргаар гэрээгээр үйл ажиллагаа эрхлэгчид гэх мэт.

Ийнхүү төлөвлөгөө боловсруулахаас өмнө бүхий л оролцогч талууд, тэдгээрийн оролцооны хэлбэр, түвшинг тодорхойлох нь дараах давуу талтай. Үүнд:

1. Бүхий л талуудын жигд оролцоог хангах, улмаар олон талын санал, санаачилга, асуудлыг төлөвлөгөөндөө тусгах боломжтой болно;
2. Төлөвлөгөө боловсруулах явцад талуудын оролцоог хэрхэн хангаж байгаа талаар хяналт, дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд оролцоог хангах боломжит нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар анханаас нь талуудын оролцоог хангах;

3. Оролцогч талууд мэдээллээр хангагдаж, менежментэд оролцох ёстой нэг тал гэдгээ ойлгон хүлээн зөвшөөрч, цаашид хэрэгжилтэд оролцох оролцоо нэмэгддэг;
4. Оролцогч талуудаас менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах хүнийг сонгох.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдийг сонгохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзана.

1. Ажлын хэсгийн гишүүн нь зөвхөн төлөвлөх бус хэрэгжүүлэхэд оролцох учраас төлөөллийг харгалзах;
2. ТХГН-ийн менежмент, нийгэм, эдийн засаг, байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг, мэдээлэлтэй эсэхийг тооцох (шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зөвлөх гишүүн ажиллуулж болно);
3. Төлөвлөгөө боловсруулах мэдлэг, чадвартай эсэх (шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зөвлөх гишүүн ажиллуулж болно);
4. Шийдвэр гаргах түвшинд талуудтай хамтран ажиллах туршлагатай эсэх;
5. Хүйсийн болон тухайн нутагт амьдарч байгаа үндэстэн, ястны төлөөллийг харгалзах;
6. Тооны хувьд хэт олон биш байх бөгөөд тодорхой хугацаанд цуглаж уулзах боломжтой, эсвэл тогтмол харилцаа холбоотой ажиллах боломжтой байх (6-8 хүний бүрэлдэхүүнтэй байх нь тохиромжтой).
7. Багийн гишүүдийн дотор төлөвлөлтийн арга зүйгээр мэргэшсэн хүнийг заавал оруулах ба зөвлөх, чиглүүлэгчийн үүргээр ажиллуулах.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдийг менежмент хариуцагч болон оролцогч талуудын төлөөллийг оролцуулан сонгохоос гадна харилцан ярилцаж тохиролцсон байх хэрэгтэй. Энэ нь ажлын хэсэгт орж ажиллах хүсэл, сонирхол бий эсэхийг харгалзаж буй хэлбэр бөгөөд цаашдын ажлын үр дүнд чухал нөлөөтэй. Гишүүдийг сонгосны дараа ажлын хэсгийн анхны хурлыг хийж дараах шийдвэрүүдийг гаргана. Үүнд:

1. Багийн ахлагчийг сонгох;
2. Гишүүдэд менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын чиглэл, төлөвлөгөө боловсруулах арга зүйг танилцуулах сургалт зохион байгуулж нэгдсэн ойлголттой болгох (арга зүйгээ сайн ойлгосон байх нь ажлын үр дүнд чухал нөлөөтэй);
3. Гишүүд хамтран зорилгоо хэлэлцэн нарийлчилсан ажлын төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргана. Мөн шаардлагатай төсвийг гаргасан байна.
4. Гишүүд, тэдний гүйцэтгэх үүрэг, ажлын төлөвлөгөөг батлан албажуулсан байна.

Ажлын хэсэг албан ёсоор байгуулагдах хүртэл дээрх ажлуудыг хамгаалалтын захиргааны дарга буюу байгууллагын удирдах албан тушаалтан удирдан чиглүүлэх ба ажлын хэсэг байгуулагдан албажсанаас хойш гишүүд үүрэг, ажлын төлөвлөгөөний дагуу менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг удирдан зохион байгуулна.

ЗӨВЛӨМЖ: Төлөвлөгөө боловсруулахад зарцуулах хугацаа, үйл явц:

Энэ нь тухайн ТХГН-ийн байгуулагдсан он, оролцогч талуудын хамтын ажиллагаа, туршлага, өмнө нь менежментийн төлөвлөгөөтэй байсан эсэхээс хамаарах боловч төлөвлөгөө боловсруулах үйл явц нь ихэнхдээ 6-9 сар үргэлжилдэг. Тиймээс төлөвлөгөө боловсруулж эхлэх хугацаагаа оновчтой сонгох хэрэгтэй. Гэхдээ энэ нь багийн гишүүдийн ур чадвар, хамтын ажиллагаа, ажлын төлөвлөгөөний чанараас хамаарна. Хийх ажил, багийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг уялдаатай, сайн төлөвлөж чадсан эсэх нь ажлын үр дүнд нөлөөлнө. Төлөвлөгөө боловсруулах нь өөрөө төлөвлөлт гэсэн бүхэл бүтэн процесс, үйл явцын нэг үе шат бөгөөд хэт их хугацаа зарцуулж удаашруулахаас татгалзах хэрэгтэй. Аргазүйн үндсэн зарчим нь дасан зохицох менежмент (Adaptive management) буюу хэрэгжилтийн явцад үнэлгээ, мониторингийг тогтмол хийж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг эргэн харж сайжруулах боломж байгааг харгалзан хамгийн бага бөгөөд тохиромжтой хугацааг сонгон багийн ажлын төлөвлөгөөг гаргах хэрэгтэй. Мөн мэдээлэл дутмаг, судалгаа хомс байдал нь төлөвлөгөө боловсруулах явцыг удаашруулах нөхцөл болох ёсгүй бөгөөд төлөвлөгөөнд тодруулах, судлах гэсэн үйл ажиллагааг тусгах байдлаар асуудлыг шийдвэрлэх боломжтойг анхаарна уу.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явц нь дараах ерөнхий дараалалтай байна. Үүнийг үндэслэн ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж болно. Үүнд:

1. Ажлын хэсгийн гишүүд цугуулах шаардлагатай анхдагч мэдээллийн жагсаалтыг гарган анхдагч мэдээлэл цуглуулах;
2. Цуглуулсан мэдээлэлд эхний байдлаар дүн шинжилгээ хийж, холбогдох талуудад танилцуулах, мэдээлэл өгөх;
3. Талуудын оролцоотойгоор өмнөх менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох арга зүйн дагуу үнэлэх;
4. Талуудын анхан шатны уулзалт хийж санал авах;
5. Үндсэн санал, мэдээлэлд тулгуурлан менежментийн төлөвлөгөөний эхний төслийг боловсруулах;
6. Төслийг талуудад танилцуулах, санал авах, дутуу хэсгийг нөхөх;
7. Менежментийн төлөвлөгөөний төслийг сайжруулж талуудын эцсийн шатны хэлэлцүүлэг хийж тохирох;
8. Менежментийн төлөвлөгөөнд саналуудыг нэгтгэн бичиж эцэслэх, батлуулах.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд сонгогдон, гүйцэтгэх үүрэг нь тодорхой болсон байна.
- Ажлын хэсгийн гишүүд арга зүйн сургалтад хамрагдаж ажлын үндсэн зорилго болон арга зүйн талаар нэгдсэн ойлголттой болсон байна.
- Ажлын хэсгийн зорилго, нарийвчилсан төлөвлөгөө, шаардагдах төсөв, түүний эх үүсвэр нь тодорхой болж баталгаажсан байна.
- Төлөвлөгөө боловсруулахад оролцогч талууд, тэдгээрийн оролцооны түвшин тодорхой болсон байна.

1.2 Хамрах хүрээг тодорхойлох:

ХАМРАХ ХҮРЭЭ, АЛСЫН ХАРААГ ТОДОРХОЙЛОХ

Юуны өмнө төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд гол оролцогч талуудтай хамтран ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлох хэрэгтэй. Энэ нь талууд юунд хүрэхийг зорьж байгаагаа ойлгож авахад чухал.

Хамрах хүрээг менежментийн төлөвлөгөө боловсруулах анхан шатны хэлэлцүүлгийн үеэр тодорхойлох нь тохиромжтой байдаг.

Хамрах хүрээг дараах нөхцөлүүдийг 1) төлөвлөгөө хэрэгжих газар нутаг, 2) үндсэн агуулга буюу үзэл баримтлал, 3) цаг хугацааны гэсэн 3 чиглэлээр тодорхойлно. Үүнд:

1. Газарзүйн байршил: Менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагаа хэрэгжих газар нутгийн хилийн заагийг тодорхой болгоно. ТХГН-ийн хувьд ихэнхдээ албан ёсоор батлагдсан хилийн зааг доторхи газар нутаг нь хамгааллын үйл ажиллагаа явуулах газарзүйн байршлын цар хүрээг тодорхойлдог (Зураг 1). Үүнд дотоод бүсчлэлийг хамруулан ойлгоно.

2. Хамгаалах үнэт зүйлд суурилан хамрах хүрээг сонгох: Энэ нь тодорхой нэг төрөл зүйл эсвэл экосистемд хамааралтай. Тухайлбал, нэг зүйлийг амьтныг хамгаалахаар төлөвлөлт хийж буй тохиолдолд ТХГН-ийн албан ёсны хилээр хязгаарлагдахгүйгээр тухайн зүйлийн хамгаалалд чухал газар нутаг эсвэл тархац нутгаар нь хамрах хүрээг сонгох шаардлагатай болно. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулж байх явцад энэ асуудлыг зайлшгүй анхаарах шаардлагатай бөгөөд газрын зурагт ТХГН-ийн хилийн гадна байгаа анхаарах шаардлагатай газрыг хамруулан зураглах замаар хамрах газар нутгийг тодорхой зааж өгнө.


3. Үйл ажиллагааны чиглэлээс хамрах хүрээг сонгох: Хамрах хүрээ нь тодорхой аюул, дарамт, боломж, нөхцөл байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх тохиолдолд түүнээс хамааран хамрах хүрээг сонгож болно. Тухайлбал: Хууль бус мод бэлтгэл эсвэл тээвэрлэлт, амьжиргаа, хоол хүнс, эрчим хүчний үйлдвэрлэлээс үүдэлтэй CO₂ ялгаралтыг бууруулах зорилготой уур амьсгалын хөтөлбөр байх тохиолдолд хамрах хүрээ нь газар нутаг гэхээс илүүтэйгээр тухайн дарамтад чиглэсэн байж болно. Энэ тохиолдолд газар нутаг бус зорилтот бүлэг, ажлын агуулга чухал байдаг. ТХГН-т хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь зарим тохиолдолд хамгаалах үнэт зүйлийнхээ амьдрах орчин, аюул, дарамтаас хамааран орчны бүсэд хэрэгжих тохиолдол цөөнгүй байдаг.

4. Цаг хугацаа: Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгасан байна.

Жишээ:**Зураг 1.**

Менежментийн
төлөвлөгөө
хэрэгжих газар
нутгийн хилийн
заагийг тодорхой
болгон зурагласан
байдал

Түргэн уулын
дархан цаазат
газар



Энэ тохиолдолд менежментийн төлөвлөгөө зөвхөн ТХГН-ийн хилийн зааг дотор хэрэгжих ба дотоод бүсийн дэглэмийг хэрэгжүүлэх, түүнд хамаарах үйл ажиллагаа менежментийн төлөвлөгөөнд туссан гэж ойлгож болно. Харин асуудал, агуулгаас хамааран хилийн гадна тодорхой үйл ажиллагаа хэрэгжих шаардлагатай бол түүнийг мөн зурагт тусган, тэмдэглэсэн байна.

ЗӨВЛӨМЖ: Уур амьсгалын өөрчлөлтийг харгалзан үзэх нь

Хамрах хүрээг тодорхойлохдоо экосистем, биологийн олон янз байдлыг хамгаалахад анхаарлаа төвлөрүүлж байгаа эсэх, тэдгээрт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлөхийг анхаарч үзэх, эсвэл экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх замаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, сааруулахад анхаарлаа хандуулж байгаа эсэхийг харгалзан үзэх хэрэгтэй. Ингэхдээ өнөөдрөөс цааш бодож, уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй хувилбаруудыг анхаарч үзээрэй. Энэ нь газарзүйн байршлын хамрах хүрээг тодорхойлоход нөлөөлж болзошгүй юм. Экосистем эсвэл сонгосон зүйлийн тархац, байршил өөрчлөгдөх, шилжих магадлалтай эсэх талаар сайн ярилцах хэрэгтэй. Ийм зүйл тохиолдож болзошгүй гэж үзвэл хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай болно.

Хамрах хүрээг шинжлэх ухааны үндэслэл бүхий мэдлэг, мэдээлэл дээр тулгуурлан тодорхойлох нь зүйтэй. Гэхдээ цаг уурын болзошгүй нөлөөг урьдчилан таамаглах боломжгүй байдаг тул таамаглалыг шалгах, менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх явцад буюу цаг хугацаа өнгөрөхөд хамрах хүрээг өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор тогтмол мониторинг хийх тодорхой шалгуур үзүүлэлт сонгон авч болно.

Алсын хараа тодорхойлох:

Алсын харааг талуудын оролцоотой хэлэлцүүлгийн эхэнд тодорхойлсон нь илүү үр дүнтэй байдаг. Ингэснээр оролцогч талуудын сонирхлыг нэгтгэн, хоорондын үл ойлголцлыг арилгахад тустай бөгөөд ирээдүйд хүрэхийг зорьж буй зорилгоо нэгтгэн тодорхой болгосноор оролцогч талууд нэг цогц зүйлийн төлөө ажиллах гэж байна гэдгээ ойлгож авдаг.

Алсын хараа нь тухайн ТХГН-ийн төлөв байдлын ирээдүйн хүссэн төлөв буюу эцсийн нөхцөл байдлыг илэрхийлсэн ерөнхий тодорхойлолт байна.

Ихэнхдээ хүн, байгалийн харилцан уялдааг хангаж, экосистем, биологийн олон янз байдал, түүх соёлын үнэт өвийг хадгалах, хамгаалах, зохистой ашиглан хөгжлийн тодорхой түвшинд хүрэх талаарх төсөөлөл бүхий хүрэхийг зорьсон үр дүн байдаг. Энэ нь тодорхойлолт хэлбэрээр бичигдэх эсвэл газрын зураг хэлбэрээр байж болох ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- бүх оролцогчид санаж байхаар энгийн бөгөөд товч, хүн бүхэнд ойлгомжтой байх;
- хэрэгжүүлэхээр зорьж буй бүхий л үйл ажиллагааг хамран өргөн хүрээнд тодорхойлсон, төсөөлсөн байх;
- хамгаалах үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдлын өөрчлөлт нь итгэл найдвар төрүүлэхүйц байх;
- хугацааны хувьд 5 эсвэл 10 эсвэл 20 жилийн дараах хүрэх үр дүн байж болох ба үүнийг менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа, зорьж буй үр дүнд хүрэх боломжит хугацаа, хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан тооцож томъёолно.

Алсын харааг томъёолохдоо тухайн ТХГН-ийг байгуулсан үндэслэл, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан эсэхэд анхаарч байна.

Жишээ:

- Хөвсгөл нуурын БЦГ-ын менежментийн төлөвлөгөөний алсын хараа:* Байгалийн үзэсгэлэнт цэнгэг уст Хөвсгөл нуурынхаа унаган төрх, онцлог хэв шинжийг хэвээр хадгалж, уламжлалт ёс заншлыг үргэлжлүүлэн экологийн тэнцвэрт байдал, биологийн төрөл зүйлийг хамгаалж, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэн, зөв, тогтвортой менежментээр нутгийн иргэдэд түшиглэн хамгаална.
- Онон Балжийн БЦГ-ын менежментийн төлөвлөгөөний алсын хараа:* Онон-Балжийн БЦГ нь ой, ус, намгархаг нутгийн амьтан, шувуудын амьдрах таатай орчин, түүх, соёлын баялаг өвд түшиглэсэн аялал жуулчлалын бүс нутаг байж, ард иргэд нь байгальтайгаа харилцан шүтэлцэж, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Хамрах хүрээг газар нутаг, анхаарах гол асуудал, төлөвлөгөө хэрэгжих цаг хугацааны хувьд тодорхойлсон байна. Энэ нь менежментийн төлөвлөгөөг ямар газар, ямар хугацаанд хэрэгжүүлэх, агуулгын хувьд юунд илүү төвлөрсөн байхыг товчоор тодорхойлон бичиж, газрын зураг хийсэн байна.
- Ирээдүйд хүрэхийг хүсч буй үр дүн болох алсын хараагаа тодорхойлсон байна.
- Алсын хараа, менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээг оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрч нэгдсэн ойлголттой болсон байна.

1.3 ХАМГААЛАХ ҮНЭТ ЗҮЙЛС, ТЭДГЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Менежментийн төлөвлөгөөнд төлөөлөл болгон хамгаалах үнэт зүйлсийг сонгох нь менежментийн төлөвлөгөөг зөв эхлүүлэх чухал алхам юм. Төлөөлөл болгож сонгон авсан хамгаалах үнэт зүйлс нь тухайн ТХГН-ийн экосистем, биологийн олон янз байдлыг төлөөлж чадахуйц байх ёстой. Эдгээр нь ихэвчлэн биологийн олон янз байдалтай хамааралтай байдаг боловч зарим тохиолдолд хүний сайн сайхны төлөөх үнэт зүйл болон түүх соёлын үнэт зүйлүүд байж болдог. Хамгаалах үнэт зүйлүүд нь алсын хараа, хамрах хүрээтэй шууд хамааралтайгаар буюу түүний хүрээнд сонгогдох ёстой.

Төлөөлөл болгон сонгох хамгаалах үнэт зүйлүүд нь дараах төрөлтэй байж болно. Үүнд:

1. Зүйл;
2. Бүлгэмдэл;
3. Экосистем;
4. Экологийн процесс;
5. Түүх, соёлын дурсгалт газар;

Менежментийн төлөвлөгөөнд төлөөлөл болгон сонгож хамгаалах үнэт зүйлсийг хэлэлцүүлгийн явцад олон талын төлөөллийн оролцоотойгоор тодорхойлох нь оновчтой байдаг. Энэ үед оролцогчид олон тооны хамгаалах үнэт зүйлүүдийн жагсаалтыг гаргаж ирэх ба эдгээрээс хамгийн чухал, тухайн газрыг төлөөлж чадахуйц хамгаалах үнэт зүйлүүдийг сонгоно. Харин тооны хувьд 8¹-аас хэтрэхгүй байх нь зүйтэй. Сонголтыг хийхийн тулд тэргүүлэх байдлаар нь эрэмбэлэх ба дараах хүчин зүйлүүдийг харгалзана. Үүнд:

1. Санал болгож буй хамгаалах үнэт зүйлүүд нь ижил амьдрах орчинд тохиолддог зүйлүүд байгаа бол нэг дор жагсаан аль нэгийг сонгох эсвэл тодорхой түвшинд ялгаатай гэж үзвэл тус тусад нь сонгож болно;
2. Ижил аюул дарамтад өртдөг зүйлүүд байвал нийлүүлж, аль нэгийг нь сонгож болно (Учир нь тэмцэх арга нь ижил байх болно);

1 Энэ нь өнөөг хүртэл хуримтлуулж ирсэн туршлагад үндэслэн гаргаж ирсэн тоо бөгөөд хэт олон байх нь төвлөрлийг сааруулж, хамгааллын ажлын үр дүнд сөргөөр нөлөөлдөг болох нь туршлагаар нотлогдсон.

3. Сонгосон үнэт зүйлүүд нь тухайн ТХГН-ийн экосистем, биологийн олон янз байдал, түүх соёлын үнэ цэнийн хувьд болон газар нутгийн онцлогийг бүрэн төлөөлж чадаж байхаа эсэхийг тооцно;
4. Нэн ховор, ховор зүйл, шүхэр эсвэл эмзэг, устаж болзошгүй эрсдэлд орж буй зүйл, экосистем байвал онцгойлон анхаарч үзэж болно;
5. Хөрөнгө санхүү босгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг нээхүйц байвал мөн сонгож болно.

Хамгаалах үнэт зүйлсийг эцэслэн сонгохдоо судлаач, холбогдох мэргэжлийн шинжээчдийн оролцоотойгоор орон зайн өгөгдөлд янз бүрийн нарийвчлалтай дүн шинжилгээ хийж, холбогдох газрын зургуудийн хийсэн байх шаардлагатай. Тиймээс хэлэлцүүлгээр тодорхойлж гаргасан хамгаалах үнэт зүйлүүдийн сонгосон үндэслэлийг нарийвчлан бичиж судлаач, мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөх нь сонголтыг оновчтой, үндэслэлтэй болгоход чухал нөлөөтэй.

Дам хамгаалагдах үнэт зүйл:

Тухайн газар нутгийн хувьд төлөөлөл болгон хамгаалах үнэт зүйлийн тоог 8-аас хэтрүүлэхгүй байх нь учир дутагдалтай байж болох боловч сонгосон хамгаалах үнэт зүйлээс гадна дам хамгаалагдах хэд хэдэн зүйлийг сонгох боломжит нөхцөл бий. Энэ нь тухайн сонгосон үнэт зүйлийг хамгаалснаар давхар хамгаалах боломжит зүйлийг тодруулж нэрлэнэ гэсэн үг юм.

Дам хамгаалагдах зүйлүүдийг ялангуяа экосистемийг хамгаалах үнэт зүйлээр сонгосон тохиолдолд сонгох нь чухал байдаг. Тэдгээр нь тухайн системийн эрүүл байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлт болох боломж, ач холбогдолтой юм. Дам хамгаалагдах үнэт зүйл нь төлөөлөл болгон хамгаалахаар сонгогдсон үнэт зүйлстэй ижил амьдрах орчин, газарт тохиолддог зүйлүүд эсвэл ижил аюул заналд өртдөг зүйлүүд байж болно.

Иймээс шаардлагатай гэж үзвэл хамгаалах үнэт зүйлүүдэд дам хамгаалагдах үнэт зүйлсийг тодорхойлон нэрлэж болно. Мөн тэдгээр нь хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг илэрхийлэх шалгуур үзүүлэлт байх боломжтой.

Жишээ:

- а) Халиун буга – хамгаалах үнэт зүйлээр сонгогдсон тохиолдолд дам хамгаалагдах зүйл нь бор гөрөөс, зэрлэг гахай. Хамгаалахаар сонгосон үнэт зүйлд учирч буй гол аюул дарамт нь хулгайн ан. Халиун бугын хулгайн анг бууруулахад чиглэсэн ажил нь зөвхөн халиун бугад хамаатай бус бөгөөд нэгэн газар зэрэгцэн оршиж, ижил төрлийн дарамтад орж буй бүх амьтад дам хамгаалагдах боломжтой. Эсвэл амьдрах орчин болох ой дам хамгаалагдах үнэт зүйл нь байж болно.

- b) Цэн тогоруу – хамгаалах үнэт зүйлээр сонгогдсон тохиолдолд дам хамгаалагдах зүйл нь ус намгархаг газар. Цэн тогорууг хамгаалах зорилго тавьж хамгааллын ажлыг эрчимжүүлснээр түүний амьдрах орчин болох ус намгархаг газрууд дам байдлаар хамгаалагдана.
- c) Ус намгархаг газар – хамгаалах үнэт зүйлээр сонгогдсон тохиолдолд дам хамгаалагдах зүйл нь цэн тогоруу, нүүдлийн шувууд болон бусад усны амьтад. Бүх ус намгархаг газрыг хамгаалах зорилго тавьж хамгааллын ажлыг эрчимжүүлснээр түүнийг шүтэн амьдрах нэн ховор зүйл болох цэн тогоруу болон бусад нүүдлийн шувууд, усны амьтад дам байдлаар хамгаалагдана. Ус намгархаг газрын хамгаалал сайн байх шалгуур нь үүрлэн өндөглөж буй цэн тогорууны тоо толгой байж болно.

Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээ:

Хамгаалах үнэт зүйлийн өнөөгийн нөхцөл байдал, өөрчлөлтийн чиг хандлага, ирээдүйн зорилгоо тодорхой болгохын тулд энэ үнэлгээг хийдэг. Энэ алхам нь төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлүүдийн өнөөгийн төлөв байдал ямар байгааг тодорхойлохоос гадна тухайн үнэт зүйлийн хэвийн төлөв буюу эрүүл байдал нь ямар хэмжээнд байх ёстой вэ гэдгийг мэдэж авахад тусална.

Төлөв байдлын үнэлгээг хийхээс өмнө Экологийн Чухал Хүчин Зүйлс (ЭЧХЗ) гэсэн ойлголтыг сайн мэдэх шаардлагатай болдог.

ЭЧХЗ гэдэг нь төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлүүдийн оршин тогтнох чадамж буюу эрүүл, хэвийн байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.

Хамгаалах үнэт зүйлүүдийн төлөв байдлыг үнэлэхдээ ЭЧХЗ-ийг шалгуур үзүүлэлт болгон сонгож авна. Шалгуур үзүүлэлт (шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлагыг 2.3 алхамаас үзнэ үү) нь дараах 3 төрөлд хамаарах ба шалгуур үзүүлэлтийг төрөл тус бүрээс сонгохыг эрмэлзсэнээр тухайн хамгаалах үнэт зүйлийн нөхцөл байдлыг бодитоор үнэлэх боломжтой болно. Шалгуурын төрөл:

- Тоо хэмжээ – Амьтан, ургамлын зүйлийн тоо, толгой, тархац нутаг гэх мэт хамгаалах үнэт зүйлийн тоо хэмжээг илэрхийлэх ойлголтууд.
- Нөхцөл – Тухайн экосистем, биологийн олон янз байдлын бүтэц, бүрэлдэхүүн, бусад амьд организмтай харилцан үйлчлэлд орох нөхцөлүүдийг ойлгоно. Тухайлбал; амьтдын хувьд хүйсийн харьцаа, үржлийн амжилт, түлхүүр зүйл болон харилцан үйлчлэлд ордог зүйлүүд байгаа эсэх зэрэг үзүүлэлт байж болно.
- Ландшафтын буюу гадаад хүчин зүйл - Хамгаалах үнэт зүйлийн оршин тогтноход чухал, хүрээлэн буй орчны үзүүлэлт буюу экологийн горим, үйл явц ба холбогдох байдал зэргийг ойлгоно. Өөрөөр хэлбэл хамгаалах үнэт зүйлд гадаад орчноос нөлөөлж буй хүчин зүйл. Тухайлбал; ойн түймэр – энэ нь ойн амьтдын хувьд амьдрах орчныг хомсдуулж буй хүчин зүйл, усны горим – улирлын өөрчлөлт, цаг хугацаа, үерийн давтамж, хамрах хүрээ зэрэг болно.


Жишээ: Экологийн чухал хүчин зүйлийн зарим жишээ

Ангилал	Экологийн чухал хүчин зүйл
Тоо хэмжээ	Популяцийн хэмжээ ба динамик
	Экосистем дэх чухал бүлгэмдлүүдийн хэмжээ эсвэл сукцессийн шат
	Голлох экосистем, амьдрах орчин, бүлгэмдлийн тоо хэмжээ
Нөхцөл	Хоол тэжээлийн олдоц
	Бүлгэмдлийн бүтэц
	Махчлал болон шимэгчлэх
	Тоос хүртээх
	Хүйсийн харьцаа
	Популяцийн бүтэц ба сэлбэгдэл
	Түлхүүр зүйл болон харилцан үйлчлэлд ордог зүйлүүд байгаа эсэх
	Зүйлийн бүрдэл – зонхилол
	Сукцессийн динамик
Ландшафтын буюу гадаад хүчин зүйл	Бүлгэмдлүүд болон экосистемүүд хоорондоо холбогдох байдал
	Түймрийн горим – цаг хугацаа, давтавж, эрчим, хамрах хүрээ
	Усны горим – улирлын өөрчлөлт, цаг хугацаа, үерийн давтамж, хамрах хүрээ
	Ландшафтын хэв шинж (алаг цоог байдал), бүтэц
	Тэжээлийн бодисын хуримтлал ба динамик
	Хөрс, хурдсын суурь байдал ба нүүх хөдөлгөөн-угаагдал
	Хөрс хурдсын бүтэц, ба химийн найрлага
	Ус-хөрсний хэм
	Усны химийн найрлага
	Усны түвшингийн хэлбэлзэл
	Цаг агаарын горим – улирал, үргэлжлэх хугацаа, эрчим, цар хүрээ

ЗӨВЛӨМЖ: Хүний сайн сайхны төлөөх зорилтыг тодорхойлох

Байгаль хамгаалах ажил эцсийн эцэст хүнд хэрхэн нөлөөлж байгааг харуулах нь бас чухал. Өөрөөр хэлбэл тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулж, байгаль хамгаалах үнэт зүйлүүдийг сонгон, хамгааллын менежментийг хэрэгжүүлсэнээр хүний сайн сайхан амьдралд хэрхэн нөлөө үзүүлэхийг илэрхийлж харуулах нь хамтрагч талууд, нутгийн иргэдэд итгэл үнэмшил, гүн гүнзгий, уялдаа холбоо бүхий ойлголтыг төрүүлж, улмаар хамтран ажиллах урам зориг, итгэл, үнэмшлийг нь нэмэгдүүлэхэд тустай. Тиймээс шаардлагатай гэж үзвэл менежментийн төлөвлөгөө боловсруулж байхдаа хамгаалах үнэт зүйлийг сонгосны дараа талуудаар хэлэлцүүлэн хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг тодорхойлж болно.

Хүний сайн сайхны төлөөх зорилтууд нь экосистемийн үйлчилгээгээр дамжуулан биологийн олон янз байдлын зорилтод нөлөөлж буй хүний сайн сайхан байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд чиглэгддэг. Өөрөөр хэлбэл төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлийг хамгаалсанаар экосистемийн ямар үйлчилгээг хангах, хамгаалах боломжтой, түүгээр дамжуулан хүн ямар үр ашиг, шимийг хүртэх боломжтойг тодорхойлох юм.



(Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-т байгаа эх сурвалжуудаас авна уу)

Түүх, соёлын үнэт зүйлийн хувьд өөрийн онцлогт тохирсон чухал үзүүлэлтийг шалгуураар сонгох боловч ерөнхий сонголт, үнэлгээний арга зүй ижил байна.

ЭЧХЗ-үүдээр шалгуур үзүүлэлт тогтоосны дараа тэдгээрийн байгалийн жам ёсны хэлбэлзлийг тодорхой болгоно (FOS, 2009; TNC, 2007). Жам ёсны хэлбэлзлийг тогтоохдоо МУУ, ДУНД, САЙН, МАШ САЙН гэсэн үнэлгээний дагуу эрэмбэлж, тэдгээрийн заагийг тогтооно (БОНХЯ, 2012). Зааг хоорондын зөрүүг дараах байдлаар шалгуур тус бүрээр тогтооно.

- *Маш сайн*: Экологийн хувьд байх ёстой түвшин, сайжруулах шаардлагагүй;
- *Сайн*: Хэлбэлзэл нь зөвшөөрөгдөхүйц хэмжээнд байгаа. Менежментийн зарим арга хэмжээ авах шаардлагатай;
- *Дунд*: Хэлбэлзэл нь зөвшөөрөгдөхүйц хэмжээнээс их болсон. Зайлшгүй хамгаалах арга хэмжээ шаардагдана.
- *Муу*: Нөхөн сэргээхэд маш хэцүү болсон. Устгах аюулд орсон.

Жишээ: Төлөв байдлын үнэлгээ

				Шалгуурын ангилал Тод=Одоогийн байдал <i>налуу=хүсч буй үр дүн</i>			
Хамгаалах үнэт зүйл	Хэмжигдэхүүний төрөл	ЭЧХЗ	Шалгуур	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Хялганат хээрийн экосистем	Ландшафтын буюу гадаад хүчин зүйл	Түймрийн давтамж	5 жилд гарах түймрийн тоо	6<	3-6 удаа	2-3 удаа	1 удаа
Халиун буга	Тоо хэмжээ	Тоо толгой	1000 га-д ногдох тоо толгой	0	1-2	2-3	3<

Төлөв байдлын үнэлгээний хамгийн гол зорилго нь хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын талаарх хүмүүсийн мэдлэг, мэдээллийг нэгтгэх явдал юм. Мэдээллийн дутагдлаас санаа зовох хэрэггүй бөгөөд хэлэлцүүлгийн дараа ч гэсэн нэмэлт мэдээлэл өгч болно. Төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйл тус бүрээр дээрхи үнэлгээг хийж нийлбэр үнэлгээг гаргана.

ЗӨВЛӨМЖ: Үнэлгээнд өнгө ашиглах нь

Олон нийтийн оролцоотой хэлэлцүүлэг хийх, судлаачдын хамтаар төлөв байдлыг тодорхойлох зэргээр төрөл бүрийг арга хэлбэрээр аливаа зүйлд "маш сайн", "сайн", "дунд", "муу" гэсэн үнэлгээ өгөхдөө өнгийг ашиглах нь тустай. Энэ нь хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээ, аюул, дарамтын үнэлгээ зэрэгт бүгдэд хамааралтай бөгөөд муу гэсэн нэг төрлийн үнэлгээнд нэг өнгийг (улаан өнгө ашиглагдсан) ашигласнаар оролцогч бүх талууд маш хялбарханаар үнэлгээний талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлдэг.

Жишээ: Төлөв байдлын үнэлгээг Миради программд оруулсан байдал – Онон Балжийн БЦГ жишээн дээр

Хамгаалах үнэт зүйл/шалгуур	Өнөөгийн төлөв байдал	ЭЧХЗ	Үнэлгээний зааг				Эх сурвалж	Явц буюу төлөв	Хүрэх түвшин
			Муу	Хэвийн	Сайн	Маш сайн			
Онон Балжийн БЦГ	Хэвийн								Сайн
Халиун буга	Хэвийн								Сайн
Тоо толгой	Хэвийн	Хэмжээ							Хэвийн
1000 га-д ногдох тоо толгой	Хэвийн		<1	1-3	4-6	7-12	Судалгааны дүн	Өсөлттэй	Хэвийн
2018-09-02:				?			Мэргэжилтний туршлага, мэдлэг		
2015-12-30:				→			Нутгийн иргэдийн аман мэдээ		
2010-12-28:				↗			Шуурхай үнэлгээ		
2010-11-12:			↗				Нутгийн иргэдийн аман мэдээ		
Ирээдүйд хүрэх төлөв					▲				
Тархац нутаг	Маш сайн	Хэмжээ							Маш сайн
Идээшил нутаг	Маш сайн		> 20	20 - 29	30 - 39	< 40	Нутгийн иргэдийн аман мэдээ	Хэвийн	Маш сайн
2018-09-02:						→	Шуурхай үнэлгээ		
2015-12-30:					↗		Нутгийн иргэдийн аман мэдээ		
2010-12-28:					↗		Шуурхай үнэлгээ		
2010-11-12:			↗				Нутгийн иргэдийн аман мэдээ		
Ирээдүйд хүрэх төлөв						▲			

Тайлбар:

	Газрын нэр
	Хамгаалах үнэт зүйл
	ЭЧХЗ
	Зорилго буюу ирээдүйн хүрэх төлөв
	Шалгуур үзүүлэлт
	Мэдээлэл оруулсан огноо
	Өөрчлөлтийн чиг хандлага

Бүх шалгуурын эрэмбийг бөглөх гэж яарсны хэрэггүй. Юуны түрүүнд өнөөгийн нөхцөл, мөн цаашид ямар түвшинд хүргэхийг хүсч байна гэдгээ мэдэж авах нь чухал. Эрэмбийг гаргахдаа нарийн тоон үзүүлэлт байхгүй бол чанарын үзүүлэлт ашиглаж болно.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Менежментийн төлөвлөгөөнд төлөөлөл болгон сонгож хамгаалах үнэт зүйлүүдээ тодорхойлсон байна. Боломжтой бол хүний сайн сайхны төлөөх зорилтуудыг тодорхойлсон байна.
- Хамгаалах үнэт зүйлүүдийн талаар хийгдсэн судалгааны үр дүн болон мэдээллүүд нэгтгэгдсэн байна.
- Хамгаалах үнэт зүйлүүдийн төлөв байдлын үнэлгээ хийгдэж, өнөөгийн төлөв, түүний өөрчлөлтийн чиг хандлагын талаар талууд нэгдсэн ойлголттой болсон байна.
- Мэдээлэлд түшиглэн төлөв байдлын хувьд ирээдүйд хүрэхийг хүсч буй үр дүнгээ тодорхой болгосон байна.
- Хамгаалах үнэт зүйл тус бүрийг хамгаалсанаар ямар экосистемийг үйлчилгээг хангах, хамгаалах, улмаар энэ нь хүний сайн сайхан амьдралд хэрхэн хувь нэмэр оруулахыг харуулсан схем, зураг, эсвэл зорилтуудыг дэвшүүлсэн байна (Үүнийг бүх зорилго, зорилтуудаа эцэслэн боловсруулсаны дараа хянаж сайжруулж болно).

1.4 АЮУЛ, ДАРАМТЫГ ТОДОРХОЙЛЖ ҮНЭЛЭХ

Аюул, дарамтыг тодорхойлох нь тухайн хамгаалах үнэт зүйлийг хомсдуулж, доройтуулахад шууд болон дам нөлөө үзүүлж буй хүчин зүйлүүдийг илрүүлж өнөөгийн нөхцөл байдлыг нарийвчлан, ирээдүйд бий болох сөрөг нөлөөг таамаглах зорилготой.

Аюул, дарамт гэдэгт дараах хүчин зүйлүүдийг хамааруулна. Үүнд:


1. Хамгаалах үнэт зүйлийг хомсдуулж, доройтуулахад өнөө цагт шууд нөлөө үзүүлж буй болон ирээдүйд нөлөөлж болзошгүй **хүний хүчин зүйл** байна. Тухайлбал, хууль бус агнуур, байгалийн нөөцийн хэт ашиглалт, замбараагүй зам, байгууламж гэх мэт.
2. Мөн **хүний шууд болон дам үйл ажиллагаанаас үүдэлтэй байгалийн үзэгдэл** байж болно. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй хуурайшил, хүчтэй шуурга гэх мэт байгалийн гамшиг, эсвэл ховор үзэгдлүүд.

Аюул, дарамтыг тодорхойлоход **аюул, дарамт** болон **түүний нөлөөгөөр бий болсон үр дүн** хоёрыг салгаж ойлгох хэрэгтэй. Тухайлбал: Усны бохирдол – энэ бол аюул, дарамт биш бөгөөд уул уурхай эсвэл малын хөлийн нөлөө зэрэг аюул, дарамтын нөлөөгөөр усан орчин бохирдсон буюу тэдгээрийн үр дүн юм. Нүүдлийн зүйлүүдийн амьдрах орчны тасархайтал – энэ зэрлэг амьтанд ээлгүй дэд бүтэц гэсэн аюул, дарамтын нөлөөгөөр бий болсон үр дүн юм. Аюул, дарамт болон түүний нөлөөгөөр бий болсон үр дүн хоёрыг салгаж ойлгох нь тэдгээрийн нөлөөг бууруулах оновчтой арга замыг сонгоход тустай.

Жишээ: Аюул, дарамт ба түүний нөлөөгөөр бий болох үр дүнгийн ялгаатай тал

Аюул, дарамт (threat)	Нөлөөллийн үр дүн (stress)	Тайлбар
Хууль бус агнуур	Тоо толгой цөөрөх	Хууль бус агнуурын шууд нөлөөнөөс шалтгаалан тухайн амьтны хувьд тоо толгой цөөрч байна гэсэн үр дүн бий болжээ.
Ган, зуд	Гол, ус ширгэх, усан хангамж багасах	Ган гэх шууд аюул, дарамтын нөлөөгөөр гол, ус ширгэж усан хангамж буурах гэсэн үр нөлөө бий болж байна.
Түймэр	Амьдрах орчны хомсдол	Түймрийн үр нөлөөгөөр амьдрах орчин хомсдож байгаа буюу түймэр бол шууд нөлөө үзүүлж буй аюул, дарамт. Харин амьдрах орчны хомсдол нь түймрийн нөлөөгөөр үүссэн үр дүн болохоос аюул, дарамт биш юм.

Жишээ: Миради программд аюул, дарамт, түүний нөлөөллийн үр дүнг тодорхойлсон байдал



Аюул, дарамтыг нөлөөллийн зэргээр нь үнэлж эрэмбэлэх:

Хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтыг тэргүүлэх буюу нөлөөллийн зэргээр эрэмбэлж үнэлэх нь чухал бөгөөд ингэснээр аюул, дарамтыг бууруулахад чиглэсэн шаардлагатай үйл ажиллагааг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх, түүнд анхаарлаа төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой. Үнэлгээ хийх явцад ялангуяа нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай аюул, дарамтыг тодорхойлоход анхаарах хэрэгтэй. Гэхдээ тухайн аюул, дарамтыг бууруулах өөрсдийн чадамж, нөөц боломжоор хязгаарлахгүйгээр бүх аюул, дарамтыг ижил түвшинд анхаарч авч үзэн үнэлгээ өгнө. Аюул, дарамтын нөлөөг үнэлж эрэмбэлэхдээ тодорхой шалгуур үзүүлэлт ашиглах бөгөөд үнэлэх хэд хэдэн арга зүй бий. Тэдгээрийн ихэнх нь тухайн хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй аюул, дарамтыг 1) хамрах хүрээ, 2) нөлөөллийн зэрэг гэсэн 2 шалгуураар үнэлж, нийлбэр дүнгээр нь нөлөөллийн ерөнхий үнэлгээг гаргаж эрэмбэлдэг. Зарим үнэлгээний арга зүйд тухайн аюул, дарамт нь байнга нөлөөлдөг эсэх, нөхөж буюу эргэн сэргээх боломж, яаралтай шийдвэрлэх шаардлагатай эсэх гэсэн нэмэлт шалгууруудыг ашигладаг. Нэмэлт шалгуур үзүүлэлтийн сонголт нь үнэлгээ өгч буй тухайн нөхцөл байдал, нөлөөнд өртөж буй хамгаалах үнэт зүйлийн онцлогоос хамаардаг. Харин энэ арга зүйн хувьд дараах 3 шалгуур үзүүлэлтээр хамгаалах үнэт зүйлд учирч буй болон болзошгүй аюул, дарамтыг үнэлж, эрэмбэлнэ. Үүнд:

1. Хамрах хүрээ (Scope)
2. Нөлөөллийн зэрэг (Severity)
3. Аюул, дарамтыг бууруулах буюу доройтсон экосистем, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх боломж (Irreversibility)

Хамрах хүрээ: Энэ нь зөвхөн орон зайн буюу газар нутгийн хэмжээг илэрхийлэх шалгуур үзүүлэлт бөгөөд харгалзах үнэлгээг дараах байдлаар өгнө. Үүнд:

Үнэлгээ	Үнэлгээнд харгалзах оноо	Тайлбар
Бага	1	Бага зэрэг буюу тухайн аюул, дарамт нь үнэлгээнд хамрагдаж буй газар нутгийн нийт талбайн 1-10%-г хамарч нөлөөлдөг
Дунд	2	Дунд зэрэг буюу тухайн аюул, дарамт нь үнэлгээнд хамрагдаж буй газар нутгийн нийт талбайн 11-30%-г хамарч нөлөөлдөг
Их	3	Их буюу тухайн аюул, дарамт нь үнэлгээнд хамрагдаж буй газар нутгийн нийт талбайн 31-70%-г хамарч нөлөөлдөг
Маш их	4	Маш их буюу тухайн аюул, дарамт нь үнэлгээнд хамрагдаж буй газар нутгийн нийт талбайн 71-100%-г хамарч нөлөөлдөг

Нөлөөллийн зэрэг: Энэ шалгуураар аюул, дарамт нь дээр тодорхойлсон хамрах хүрээнд хамгаалах үнэт зүйлсийн төлөв байдлыг хомсдуулж, доройтуулахад хир зэрэг хүчтэй нөлөөлж байгааг буюу нөлөөллийн хүчийг үнэлнэ (Хохирлын түвшин гэж ойлгоно). Үнэлгээний харгалзах түвшинг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Үнэлгээ	Үнэлгээнд харгалзах оноо	Тайлбар
Бага	1	Бага зэрэг нөлөөлдөг буюу 3 үе удам эсвэл 10 жилийн дотор тухайн аюул, дарамт нь хамгааллын үнэт зүйлийг 1-10%-иар бууруулах эсвэл доройтуулах
Дунд	2	Дунд зэрэг нөлөөлдөг буюу 3 үе удам эсвэл 10 жилийн дотор тухайн аюул, дарамт нь хамгааллын үнэт зүйлийг 11-30%-иар бууруулах эсвэл доройтуулах
Их	3	Их нөлөөлдөг буюу 3 үе удам эсвэл 10 жилийн дотор тухайн аюул, дарамт нь хамгааллын үнэт зүйлийг 31-70%-иар бууруулах эсвэл доройтуулах
Маш их	4	Маш их нөлөөлдөг буюу 3 үе удам эсвэл 10 жилийн дотор тухайн аюул, дарамт нь хамгааллын үнэт зүйлийг 71-100%-иар бууруулах эсвэл доройтуулах. Өөрөөр хэлбэл доройтуулах, хомсдуулах гол шалтгаан.

Аюул, дарамтыг бууруулах буюу доройтсон экосистем, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх боломж: Хамгаалах үнэт зүйлсийг хомсдуулж, доройтуулж буй аюул, дарамтыг бууруулах эсвэл тухайн аюул, дарамтыг хөнөөлгүй болгоход зарцуулах цаг хугацаа, үйл ажиллагаа, хөрөнгө зардлыг харгалзан дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

Үнэлгээ	Үнэлгээнд харгалзах оноо	Тайлбар
Бага	1	Аюул, дарамтыг бууруулах боломжтой буюу хялбар ажиллагаа, бага зардлаар, 0-5 жилийн дотор шийдвэрлэж болно. Сөрөг нөлөөллийн үр дагавар буюу хөнөөл нь хялбар арилах боломжтой.
Дунд	2	Аюул, дарамтыг бууруулах боломжтой боловч олон талт үйл ажиллагаа, тодорхой хэмжээний зардал шаардах ба 6-20 жилийн хугацаанд шийдвэрлэж болно. Сөрөг нөлөөллийн үр дагавар буюу хөнөөл нь мөн хугацаанд арилах боломжтой.

Их	3	Аюул, дарамтыг бууруулахад техник, технологийн тусламж шаардлагатай бөгөөд ихээхэн зардлаар, 21-100 жилийн хугацаанд шийвдэрлэх боломжтой. Үр дагавар буюу хөнөөл нь арилахад бэрхшээлтэй, хугацаа их шаардана.
Маш их	4	Аюул, дарамтыг бууруулахад бэрхшээлтэй буюу ихээхэн зардлаар, 100-аас дээш жил зарцуулна. Сөрөг нөлөөллийн үр дагавар буюу хөнөөлийг арилгах боломжгүй.

Шалгуур тус бүрийн оноог нэгтгэн тухайн аюул, дарамтын хувьд эцсийн үнэлгээг дараах байдлаар гаргана.

1. Хамрах хүрээ, нөлөөллийн зэрэг гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хам нөлөөний дундаж үзүүлэлтийг дараах хүснэгтийг ашиглан гаргана. Хамрах хүрээ, нөлөөллийн зэрэг гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хавсарсан нөлөө нь хамгааллын үнэт зүйлд учирч буй аюул, дарамтын түвшин, цар хүрээг тодорхойлох гол үзүүлэлт байдаг.

		Хамрах хүрээ			
		4-Маш их	3-Их	2-Дунд	1-Бага
Нөлөөллийн зэрэг	4-Маш их	4-Маш их	3-Их	2-Дунд	1-Бага
	3-Их	3-Их	3-Их	2-Дунд	1-Бага
	2-Дунд	2-Дунд	2-Дунд	2-Дунд	1-Бага
	1-Бага	1-Бага	1-Бага	1-Бага	1-Бага

2. Дээрх хам нөлөөллийн дундаж үнэлгээг 3 дахь шалгуурын үнэлгээний дүнтэй харьцуулан тооцох замаар нэгдсэн үнэлгээг гаргана.

		Аюул, дарамтыг бууруулах буюу доройтсон экосистем, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх боломж			
		4-Маш их	3-Их	2-Дунд	1-Бага
Хамрах хүрээ, нөлөөллийн зэргийн хам нөлөө	4-Маш их	4-Маш их	4-Маш их	4-Маш их	3-Их
	3-Их	4-Маш их	3-Их	3-Их	2-Дунд
	2-Дунд	3-Их	2-Дунд	2-Дунд	1-Бага
	1-Бага	2-Дунд	1-Бага	1-Бага	1-Бага

Аюул, дарамтын үнэлгээний дүнг өмнө онуудад хийсэн үнэлгээний дүнтэй харьцуулахдаа тухайн үнэт зүйлд хамаарах (БАГА, ДУНД, ИХ, МАШ ИХ) нэгдсэн үнэлгээний дүнг харгалзах 1-4 хүртэлх тоон утгаар илэрхийлэн хооронд нь харьцуулан өөрчлөлтийг дүгнэж болно.

Нэг хамгаалах үнэт зүйлд олон аюул, дарамт нөлөөлж буй тохиолдолд аюул, дарамт тус бүрийн нэгдсэн үнэлгээнд харгалзах онооны дундачийг олох замаар тухайн ТХГН-ийн хэмжээнд хамгаалах үнэт зүйлд нөлөөлж буй аюул, дарамтын нийлбэр зэргийг тодорхойлж дүгнэнэ.

Жишээ: Хар ямаатын БНГ-ын менежментийн төлөвлөгөөнд төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтын үнэлгээ, харьцуулсан үзүүлэлт


Аюул, дарамт/ Төлөөлөл болгон сонгосон хамгааллын үнэт зүйл	Үнэлгээ хийсэн он	Бор гөрөөс	Улиангаран төгөл, сөөглөг ургамал	Хэрлэн голын татам	Хялганат хээр	Булаг шанд	Аюул, дарамтын ерөнхий үнэлгээ
Бургасны зохисгүй ашиглалт	2014			ИХ			ДУНД
	2018	Нөлөөллийг эрс багассан гэж үзсэн.					
Хортон шавж	2014		БАГА				БАГА
	2018	Нөлөөллийг эрс багассан гэж үзсэн.					
Хог хаягдал	2014		БАГА	БАГА			БАГА
	2018	Нөлөөллийг эрс багассан гэж үзсэн.					
Хуурайшил	2014	ИХ	ИХ	ИХ	БАГА		ИХ
	2018	БАГА	ИХ	ИХ	БАГА	ДУНД	ИХ
Замбараагүй зам	2014	БАГА			БАГА		БАГА
	2018	БАГА			БАГА		БАГА
Газар тариалан	2014				БАГА		
	2018	Шууд дарамт болохгүй тул үнэлээгүй.					
Уул уурхай	2014	БАГА	БАГА	БАГА	БАГА		БАГА
	2018	БАГА	БАГА		БАГА	БАГА	БАГА
Түймэр	2014	БАГА	БАГА	БАГА	БАГА		БАГА
	2018	ДУНД	ИХ		БАГА		ДУНД
Байгалийн дагалдах баялгийн зохисгүй ашиглалт	2014		ДУНД		ДУНД		ДУНД
	2018	Нөлөөллийг эрс багассан гэж үзсэн.					
Бэлчээрийн талхигдал	2014	ИХ	ИХ	ИХ	ДУНД		ИХ
	2018	ДУНД	ДУНД	МАШ ИХ	ДУНД	ИХ	ИХ
Хулгайн ан	2014	ИХ			ИХ		ИХ
	2018	БАГА			ДУНД		БАГА
Орчны бүс дэх уул уурхай	2014	БАГА	БАГА	БАГА	ДУНД		БАГА
	2018	БАГА	БАГА		БАГА		БАГА
Хамгаалах үнэт зүйлийн ерөнхий үнэлгээ	2014	ИХ	ИХ	ИХ	ДУНД		ИХ
	2018	ДУНД	ИХ	ИХ	ДУНД	ДУНД	ИХ

ЗӨВЛӨМЖ: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харгалзах нь

Уур амьсгалын өөрчлөлт нь хамгаалах үнэт зүйлийн хувьд шинэ аюул, дарамтыг бий болгох, эсвэл бусад нийтлэг аюул, дарамттай харилцан нөлөөлж, нөлөөллийн хүчийг илүү хурцатгах магадлалтай. Тиймээс нөлөөллийг зайлшгүй тооцон үзэх хэрэгтэй.

Уур амьсгалын болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлсэн эмзэг байдлын үнэлгээ нь ихэнхдээ бүс нутгийн хэмжээнд хийгдсэн байдаг бөгөөд үр дүнг нь ашиглах боломжтой. Уур амьсгал хэрхэн өөрчлөгдөх, түүнд ямар хариу үйлдэл үзүүлэх, экосистем болон биологийн төрөл зүйлүүд хэрхэн оршин тогтнох зэрэг тодорхойгүй асуулууд гарч ирэх тул ирээдүйд болзошгүй өөрчлөлтийн хүрээ, хязгаарыг ойлгож мэдэхийн тулд талуудын оролцоотойгоор байгаа суурь мэдээлэлд үндэслэн энгийн дүн шинжилгээ хийж, цаашдын төлөвлөлтөдөө тусгах нь зүйтэй.

Жишээ: Увс нуурын ДЦГ-ын менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харгалзсан дүн шинжилгээ хийсэн байдал



Аюул, дарамтыг зураглах:

ТХГН-ийн хувьд аюул, дарамтыг тодорхойлон, түүний нөлөөг үнэлж эрэмбэлэхээс гадна яг ямар аюул, дарамт хаана учирч байгааг зураглах асуудал хамгийн чухал байдаг. Ингэснээр ямар төрлийн экосистем, ямар амьтан, ургамал, хаана илүү ихээр сөрөг нөлөөнд өртөж байгааг тогтоох, улмаар ирээдүйд хаана, юу хийхийг тодорхойлон гаргахад нэн чухал. Тиймээс өмнө хийсэн судалгаа, мониторингийн дүн мэдээ эсвэл шинжлэх ухааны баталгаат мэдээлэл, байхгүй тохиолдолд нутгийн иргэдийн аман мэдээлэлд тулгуурлан сөрөг нөлөөллийг харуулсан газрын зураг хийнэ. Үүнийг хамгаалах үнэт зүйлийн байршилтай давхцуулснаар стратегийн зорилт, үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, ирээдүйн газар ашиглалтын зураглалыг тодорхой бөгөөд оновчтой тодорхойлох замаар учирч болзошгүй сөрөг нөлөөг сааруулах, бууруулахад чухал ач холбогдолтой.


Газар ашиглалтын өнөөгийн байдлыг зураглах нь нэн чухал. Энэ нь нэг талаас ТХГН-ийн экосистем, биологийн олон янз байдлын хувьд түүнээс хамаарч хаана, ямар эрсдэл, аюул дарамт бий болгож байгаа, нөгөө талаар ирээдүйд ТХГН-ийн зорилго, хуулийн хүрээнд хаана, ямар зорилгоор, хир хэмжээний газрыг хэрхэн ашиглуулахыг үндэслэлтэйгээр тодорхойлоход хэрэгтэй байх болно. Газар ашиглалтыг зураглахдаа дараах үзүүлэлтүүдийг оруулсан байна. Үүнд:

1. Экосистем
2. Төлөөлөл болгон сонгосон зүйлүүдийн тархац, байршил
3. Газар ашиглалтын хэлбэр тус бүрээр оруулах /орчны бүс дэх мэдээлэл байгаа тохиолдолд оруулах нь ач холбогдолтой/
4. Дотоод бүс

Хэрэв тухайн ТХГН нь шинээр байгуулагдсан, эсвэл мэдээлэл хомс байгаа нөхцөлд газрын төлөв байдлыг харуулсан тойм зураг хэлэлцүүлгийн явцад хийж болох ба менежментийн төлөвлөгөөнд энэ төрлийн дүн шинжилгээг хийх ажлыг заавал тусгана.



Жишээ: Хар ямаатын БНГ-т хяналт шалгалт хийх чиглэл, бүсчлэл тогтооходоо аюул, дарамтын нөлөөг харгалзсан байдал



1-р бүсэд олон төрлийн зөрчил гарах магадлал өндөр тул энд хяналт шалгалтыг тогтмол хийх;


2-р бүсэд зөвхөн хулгайн ан гардаг тул хулгайн ан гарах магадлал өндөр үед хяналтыг эрчимжүүлэх;

3-р бүсэд хууль бус мод бэлтгэл гарах магадлалтай тул зөрчил гарах магадлал их үед хяналтыг эрчимжүүлэх;

4-р бүсэд зөрчил бага тул хяналтыг улиралд 1 удаа хийх боломжтой.



Жишээ: Тосон-Хулстайн БНГ, түүний орчмын газар ашиглалт



ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтыг тодорхойлж үнэлсэн байна.
- Аюул, дарамт тус бүрийн нөлөөг харуулсан болон нэгтгэн боловсруулсан газрын зураг хийсэн байна.

1.5 ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ


Нөхцөл байдлын дүн шинжилгээ гэдэг нь төлөөлөл болгон сонгосон хамгаалах үнэт зүйлүүдэд учирч буй аюул, дарамтыг үүсгэж буй хүчин зүйлс, шалтгаан, хамгааллын менежментэд учирч буй бэрхшээл, эсвэл боломжийг тодорхойлох явдал юм. Аюул, дарамтыг бий болгож буй шалтгаан, эсвэл боломжууд нь орон нутгийн шинж чанартайгаас авхуулаад олон улсын түвшний асуудлыг ч агуулсан байдаг.

Шалтгаан, боломжийг тодорхойлоход ашиглах гол түлхүүр асуулт нь ЯАГААД буюу ямар шалтгааны улмаас энэ аюул, дарамт бий болж байгааг бүхий л оролцогч талуудын хамтын оролцоотойгоор тодорхойлно. Ингэснээр шалтгаан үр дагаврыг бодитоор тодорхойлох, улмаар асуудлыг шийдэх шийдэл, боломжийг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой. Нөгөө талаар шалтгаан, боломж бүр хамтран ажиллах шаардлагатай талуудыг тодорхой болгож өгдөг. Энэ нь хувь хүн, хэсэг бүлэг, эсвэл байгууллага байж болох ба өөрөөр хэлбэл, энэ үе шатанд хамтран ажиллах талууд, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхой болгох боломжтой байдаг. Аюул, дарамт, түүнд нөлөөлж буй гол шалтгааныг бууруулах, сааруулах арга замаа сонгон, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд эдгээр талуудын дэмжлэгийг авах эсвэл ашиг сонирхолтой нь зөрчилдөх магадлалтай. Тиймээс хамтран ажиллах талуудаа тодорхойлж жагсаан эрэмбэлэх нь үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлнэ. Мөн учирч болох эрсдлээс аль аль тал нь сэргийлэхэд дөхөм болно.

Нөхцөл байдлын дүн шинжилгээг талуудын анхан шатны хэлэлцүүлгийн үеэр хийх нь оновчтой байдаг.



Жишээ: Дарьгангын БЦГ-ын нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм



ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Аюул, дарамтыг үүсгэж буй шалтгааны дүн шинжилгээ хийгдсэн байна.
- Хамтран ажиллах талууд, хамтран ажиллах арга зам тодорхой болсон байна.



ТОДОРХОЙЛОХ



ТӨЛӨВЛӨХ




ХЭРЭГЖҮҮЛЭХ



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ,
УЯЛДУУЛАХ



ҮР ДҮНГ
ХУВААЛЦАХ





ТӨЛӨВЛӨХ

Өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хамгаалах үнэт зүйлүүдэд тулгарч буй аюул, дарамт, тэдгээрийг үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлсны дараах үе шат бол **ирээдүйн зорилго, түүнд хүрэх арга замаа тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх** явдал юм.

Энэ үе шат дараах алхамаас бүрдэнэ. Үүнд:

2.1 Зорилго, стратеги, зорилт

2.2 Үйл ажиллагааны төлөвлөгөө

2.3 Мониторингийн төлөвлөгөө

2.1. ЗОРИЛГО, СТРАТЕГИ, ЗОРИЛТОО ТОДОРХОЙЛОХ

2.1.1 Зорилго тодорхойлох

Зорилгоо тодорхойлох нь төлөвлөгөөний хамгийн чухал хэсгийн нэг байдаг. Зорилго нь хамгаалахаар сонгосон үнэт зүйлийн ирээдүйн төлөв байдал буюу стратегийн зорилтуудыг хэрэгжүүлснээр хүрэх түвшин – хүлээгдэж буй үр дүнг нарийвчилан томъёолсон тодорхойлолт байна. Зорилгоо хамгаалахаар сонгосон үнэт зүйл тус бүр дээр тодорхойлно.

Зорилго тодорхойлохдоо дараах нөхцөлүүдийг зайлшгүй харгалзан үзнэ. Үүнд:

1. Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлыг үнэлсэн судалгааны мэдээ, баримт, өгөгдлийг харьцуулан дүгнэж ирээдүйн өөрчлөлтийн боломжийг тодорхойлно.
 - a. Ашиглаж буй судалгааны мэдээ, баримт нь өөр өөр жилүүдэд хийсэн бол улирал, сарын хувьд ижил түвшинд байх сонголт хийхийг эрмэлзэнэ. Тухайлбал, амьтны тоо толгойн өсөлт эсвэл бууралтын хувьд 10-р сард хийсэн судалгааны дүнг 4-р сард хийсэн судалгааны дүнтэй харьцуулах нь бодит байдалд нийцэхгүй;
 - b. Өөр өөр шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар өгсөн үнэлгээний дүнг харьцуулахгүй байх;
 - c. Ижил арга зүйгээр хийсэн үнэлгээний дүнг харьцуулах. Хэдийгээр нэг чиглэлийн судалгаа боловч өөр өөр арга ашиглан хийсэн бол харьцуулах боломжгүй юм.
2. Судалгаа нь давтан хийгдээгүй, эсвэл мэдээлэл байхгүй тохиолдолд менежментийн төлөвлөгөө боловсруулах хэлэлцүүлэгт оролцогчдын мэдлэг, туршлагад тулгуурлан тэдний аман мэдээлэл, практик мэдлэгийг ашиглаж болох боловч

зайлшгүй эх сурвалж, дүгнэлт өгч буй нөхцөл байдлыг тодорхой зааж бичнэ.

3. Зорилго нь улсын, бүс нутгийн түвшинд дэвшүүлсэн зорилт болон өмнөх шатанд тодорхойлсон алсын хараатайгаа уялдаатай байна.

Зорилгын хэрэгжилтийн хугацааны хувьд ихэнхдээ 10 жилийн дараа хүрэх үр дүнг тодорхойлсон байх хандлага давамгайлдаг боловч төлөвлөгөө боловсруулахад оролцож буй хүмүүсийн санал, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа болон бодит хэрэгцээнд тулгуурлан 5-аас 10 хүртэлх жилийн хугацаанд хүрэхээр төлөвлөж болно.

Зорилго нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:

1. **Хамгаалах үнэт зүйлтэйгээ шууд холбогдсон:** Нэг эсвэл хэд хэдэн хамгаалах үнэт зүйлтэй хамааралтай байж болно;
2. **Үр дүнд чиглэсэн:** Тодорхой хугацааны дараа хүрэхээр зорьж буй хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал буюу хүрэх үр дүнг илэрхийлсэн байх;
3. **Тодорхой томъёолсон:** Төлөвлөлтийн бүх үе шатанд оролцогч хүн бүр ижил түвшний ойлголт авахуйц тодорхой томъёолсон буюу хоёрдмол утга агуулаагүй байх;
4. **Хэмжигдэхүйц:** Тоон холбогдол бүхий хэмжигдэхүүнээр илэрхийлэгдсэн, үр дүнг нь хэмжиж болохуйц байх;
5. **Тодорхой хугацааны хязгаартай:** Тодорхой хугацааны дотор тухайн үр дүндээ хүрэхээр заасан ба тийм боломжтой байх.

ЗӨВЛӨМЖ: Уур амьсгалын өөрчлөлтийг харгалзах нь:

Зорилгоо томъёолохдоо хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммаа эргэн хараарай. Тухайн хамгаалах үнэт зүйл нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөж байгаа эсвэл ирээдүйд өртөхөөр бол ийм нөхцөлд ч тухайн зорилгоо биелүүлэх боломжтой байх ёстойг анхаарна уу.

Жишээ 1: Онон-Балжийн БЦГ-ын менежментийн төлөвлөгөө (2019- 2023)-д сонгогдсон хамгаалах үнэт зүйл болох халиун бугын тухайд дэвшүүлсэн зорилгыг жишээ болгон авч үзье. Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээнээс харахад:

- 2010 онд хийсэн судалгаагаар халиун буга 1000 га-д 1.4 бодгаль ноогдох нягтшилтайгаар ОББЦГ-ын хэмжээнд 220 орчим бодгаль;

- Дээрхтэй ижил арга зүйгээр 2012 онд хийсэн судалгаагаар халиун буга 1000 га-д 2,0 бодгаль ноогдох нягтшилтайгаар ОББЦГ-ын хэмжээнд 300 ± 62 орчим бодгаль байсан;
- 2015 оны байдлаар албан ёсоор судалгаа хийгдээгүй боловч хэлэлцүүлэгт оролцогчдын аман мэдээллээс дүгнэлт хийж үзэхэд тоо толгойн өсөлт хэвийн буюу өмнөх жилүүдтэй харьцуулахад өсөлтийн эрчим буурсан, харин тархац нутгийн хэмжээ нь ОББЦГ-т хэвийн буюу байршсан газраа тогтвортой байгаа бөгөөд харин орчны бүс нутагруу тэлсэн, тэнд харагдах болсон байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзээд зорилгоо дараах байдлаар томъёолжээ.

Зорилго 1: 2022 он гэхэд ОББЦГ болон орчны бүс нутагт халиун бугын тоо толгойг 2012 оны түвшинтэй харьцуулахад 2 дахин, тархац нутгийг 20 хувиар нэмэгдүүлнэ (*Шалгуур үзүүлэлт*: 1000 га-д ногдох тоо, толгой, тархац (цөм байршил нутаг км², идээшил нутаг %).

2.1.2 Стратеги тодорхойлох

Зорилгоо тодорхойлсны дараах алхам бол түүнд хүрэхийн тулд яг юу хийх шаардлагатай талаар хэлэлцэн гол арга зам буюу стратегиэ тодорхойлох явдал юм.

Гол шалтгааныг олох:

Юуны өмнө өмнөх үе шатанд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммд бичигдсэн аюул, дарамтыг үүсгэж буй шалтгаануудаас хамгийн гол шалтгааныг олж тогтооно. Ингэхдээ дараах асуултуудын дагуу хэлэлцэнэ. Үүнд:

1. Хамгаалах үнэт зүйлийг хомсдуулж доройтуулахад нөлөөлж буй гол аюул, дарамт аль нь байна вэ? – Аюул, дарамтын үнэлгээг харна уу.
2. Тухайн аюул, дарамтыг үүсгэж буй гол шалтгаан аль нь байна вэ?
3. Ямар аюул, дарамт, шалтгааны нөлөөг нэн тэргүүнд бууруулах шаардлагатай байна вэ?
4. Энэ нь гол шалтгаан мөн үү?
5. Аюул, дарамтыг шууд бууруулах боломж байна уу?
6. Гол шалтгааныг арилгах эсвэл аюул, дарамтыг бууруулснаар хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлыг сайжруулах эсвэл нөхөн сэргээх боломжийг бүрдүүлж чадах уу?

Хэрэв олон шалтгаан сонгогдсон тохиолдолд тэргүүлэх зэргээр нь эрэмбэлэх замаар зайлшгүй анхаарч арилгах шаардлагатай гол шалтгаануудыг олж тогтооно. Ингэхдээ зорилгодоо хүрэхэд хамгийн ихээр нөлөөлж, хөшүүрэг болж чадахуйц шалтгааныг тогтоохыг хичээх хэрэгтэй. Үнэлгээ хийхдээ дараах нөхцөлүүдийг харгалзана. Үүнд:

1. Аюул, дарамтыг бууруулахад шууд нөлөөлж чадах уу?
2. Олон аюул, дарамтыг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл болж байна уу?
3. Яаралтай шийдвэрлэх шаардлагатай юу?
4. Хамгийн эцсийн шалтгаан болж байна уу?


Стратеги тодорхойлох:

Гол нөлөө үзүүлж буй шалтгаануудыг эрэмбээр нь жагсаагаад тэдгээрийг бууруулах боломжит арга замуудыг хэлэлцэн түүний ард бичиж нөлөө, шалтгаан, аюул, дарамтыг бууруулахад чиглэсэн стратегиүдийг тодорхойлно. Стратеги нь дараах чиглэлтэй байж болно. Үүнд:

1. Ихэнх тохиолдолд аюул, дарамтыг үүсгэж буй шалтгаануудаас **гол шалтгааныг тогтоон түүнийг бууруулах** эсвэл шийдвэрлэхэд чиглэсэн оновчтой арга зам буюу стратегийг тодорхойлдог. Энэ нь тэдгээрийг хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтыг бууруулахад хөшүүрэг болгон ашиглаж байгаа явдал юм.
2. Зарим тохиолдолд **аюул, дарамтыг шууд бууруулах** шаардлагатай эсвэл боломжтой гэж үзвэл аюул, дарамтыг шууд бууруулах байдлаар стратегиэ тодорхойлж болно. Тухайлбал, тухайн экосистемд харь зүйл орж ирснээр экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байгаа бол харь зүйлийг устгах гэсэн шууд стратеги дэвшүүлж болно.
3. Хамгаалах үнэт зүйлийн хомсдол, доройтлыг бууруулахын тулд **шууд хамгаалах үнэт зүйлд чиглэсэн нөхөн сэргээх** арга хэмжээ байж болно.



Жишээ 1: Голлох шалтгааныг олж, стратеги тодорхойлсон байдлыг харуулсан диаграмм



ЗӨВЛӨМЖ: Уур амьсгалын өөрчлөлтийг харгалзах нь:

Уур амьсгалын өөрчлөлт тухайн сонгосон хамгаалах үнэт зүйлд тулгарч буй аюул, дарамтын нэг, ирээдүйд ч нөлөөлөхөөр байгаа бол менежментийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд стратеги тодорхойлохдоо харгалзан үзэх хэрэгтэй. Үүний тулд сонгосон стратеги нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад шууд чиглэсэн эсвэл дам утгаараа нөлөөлж чадахуйц байгаа эсэхийг анхааран хэлэлцэнэ. Ингэхдээ дараах боломжуудыг ашиглаж болно. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр тухайн хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал доройтож байгаа бол уур амьсгалын өөрчлөлттэй шууд холбоогүй боловч уур амьсгалын өөрчлөлтийг эрчимжүүлэхэд дам нөлөөлж буй бусад аюул, дарамтыг тогтоон тэдгээрийг бууруулахад анхаарах. Тухайлбал: Орчны усны горимын өөрчлөлтөөс хамаарсан температурын бууралтыг сааруулахын тулд татмын ойн ашиглалтыг багасгах, усны зохисгүй ашиглалтыг багасган усны горимыг хэвээр хадгалан үлдэхэд анхаарснаар дам нөлөөг сааруулахад хувь нэмрээ оруулах боломжтой юм.
2. Уур амьсгал, түүний өөрчлөлттэй холбоотойгоор үүсэж буй сөрөг нөлөөг бууруулах, сааруулахын тулд хамгаалах үнэт зүйлүүдийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх. Тухайлбал: Ганд тэсвэртэй зүйлүүдийн амьдрах орчныг нөхөн сэргээх замаар зүйлүүдийн тархацыг хадгалах, нэмэгдүүлэх боломжтой.
3. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртсөн хамгаалах үнэт зүйлийн дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтөд хамааралгүй бусад аюул, дарамтыг бууруулах арга хэмжээг авах. Жишээ нь: Нүүдлийн зүйлүүдийн тухайд дэд бүтцийн хөгжлөөс хамааран нүүрлэж буй аюул, дарамт болох үндсэн амьдрах орчны тасархайтлыг арилгах, түүнээс сэргийлэх. Амьдрах орчны хоорондох холбоог хангах боломжит газар нутгийг сонгон хамгаалах ба ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн улмаас доройтож буй үндсэн амьдрах орчноос илүү тохиромжтой газруудад шилжих, түүнд дасан зохицох боломжийг бүрдүүлж буй хэрэг юм.
4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд харьцангуйгаар бага өртөх хамгаалах үнэт зүйлийг сонгон хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

Оновчтой хувилбарыг сонгох:

Оновчтой стратеги тодорхойлохын тулд дараах байдлаар ажиллаж сонголт хийнэ. Үүнд:

1. Одоо хэрэгжиж байгаа стратеги, үйл ажиллагаа тэдгээрийн үр нөлөөг шинжлэх, үргэлжлүүлэх боломжтой эсэхийг харгалзах;
2. Шинэ стратеги тодорхойлох;
3. Тэдгээрээс оновчтой стратегийг сонгох.

Одоо хэрэгжиж байгаа стратегийг судлах, үр нөлөөг шинжлэх нь бусад хүмүүс энэ нөхцөл байдалд хэрхэн ажиллаж, ямар байдлаар оролцож байгаа, түүнчлэн тэдгээр үйл ажиллагаа нь амжилттай эсвэл амжилтгүй болсон уу, яагаад гэдгийг нягтлан цаашид үргэлжлүүлэх боломжтой эсэхийг тогтоох зорилготой.

Шинэ стратеги тодорхойлох нь нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн янз бүрийн боломжит шинэлэг шийдлүүдийг гаргаж ирэх боломжийг олгоно.

Ийнхүү одоо хэрэгжиж байгаа болон шинээр дэвшүүлж буй зэрэг дүн шинжилгээ хийн хэлэлцэх нь байгаль хамгаалах зорилгодоо хэрхэн хүрэх, сонгосон стратеги нь хэрэгжүүлэх боломжтой эсвэл боломжгүй эсэхийг дахин нягтлах замаар оновчтой стратеги сонгоход хөтлөх давуу талтай - чухал алхам юм.

Стратеги нь дараах шаардлагуудад нийцсэн байх ёстой. Үүнд:

1. Хамгаалах үнэт зүйлийн тухайд хүрэхээр төлөвлөсөн үр дүн болох дэвшүүлсэн зорилгод хүрэхүйц буюу холбоо хамааралтай;
2. Нэг буюу хэд хэдэн аюул, дарамт эсвэл гол шалтгааныг бууруулахад шууд нөлөөлөхүйц;
3. Гол асуудалд анхаарал хандуулсан буюу хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхой нэгэн чиглэлд хөтөлсөн;
4. Санхүү, хүний нөөц, хамтын ажиллагааны нөөц боломж, чадавхид суурилсан, хэрэгжүүлэх боломжтой;
5. Зөв, зохистой буюу экосистем, биологийн олон янз байдал, соёл, нийгмийн хэм хэмжээнд тохирсон, хүлээн зөвшөөрөгдөхүйц.

Түүнчлэн оролцогч талуудын сонирхол татах, нийтлэг сонирхолд нийцсэн, оролцогч талуудын хооронд үүсэж болзошгүй зөрчлийг хязгаарлах эсвэл сонирхогч талуудын дэмжлэгийг бий болгох стратегийг сонгох нь чухал байдаг.

Бүх шалгуурууд дээр өндөр оноо авах эсвэл бидний болон сонирхогч талуудын ашиг сонирхлыг бүгдийг нь хангах стратегийг тодорхойлоход хэцүү учраас зарим талаар аль нэг хүчин зүйл, шалгуур дээр буулт хийх байдлаар оновчтой стратегийг сонгох шийдвэрийг гаргана.

2.1.3 Зорилт тодорхойлох

Үр дүнгийн хэлхээ:

Байгаль хамгаалах зорилгодоо хүрэхэд сонгосон стратеги нь хэрхэн хувь нэмрээ оруулах вэ гэдгийг илүү тодруулах, түүндээ итгэлтэй байхын тулд ирээдүйд бий болох явцын үр дүнгийн талаар таамаглал дэвшүүлэн хэлэлцэх хэрэгтэй. Үр дүнгийн хэлхээ хийх замаар үүнийг тодорхой гаргаж болно.

Үр дүнгийн хэлхээ бол хамгаалах үнэт зүйлд чиглэсэн урт хугацааны үр дүнд хүргэхийн тулд завсрын үр дүн, тэдгээрийн дэвшлийг таамаглаж дүрслэн харуулах нэг арга (схем) юм.


Үр дүнгийн хэлхээг хийхдээ сонгосон стратеги тус бүрээр хэлэлцэх ба стартегийг хэрэгжүүлснээр ямар завсарын болон эцсийн үр дүнг гаргах боломжтой буюу тэдгээр нь ямар аюул, дарамтыг бууруулж, аль хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлыг сайржуулахад хэрхэн тусалж болох талаар таамаглал дэвшүүлэн хэлэлцэнэ. Үр дүнгийн хэлхээ нь сонгосон стратеги нь “хамгаалах үнэт зүйлийн өнөөгийн нөхцөл байдал”-г “хүссэн нөхцөл байдал”-д хүргэхэд хэрхэн хувь нэмрээ оруулахыг диаграммаар илэрхийлэн хялбар аргаар харах боломжийг олгодог.

Үр дүнгийн хэлхээг хийхдээ дараах 2 арга хэрэглэж болно.

1. Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммаа үр дүнгийн хэлхээ хийхдээ хөрвүүлэн ашиглаж болно (Диаграмм). Өөрөөр хэлбэл, шалтгаан, боломжуудыг буцаагаад завсрын үр дүн болгон хувиргах байдлаар хийж болно.
2. Шууд сонгосон стратегийгээ шалтгаануудыг үл харгалзан юу хийж болох ямар үр дүн гаргах, тэр нь аль аюул дарамтыг бууруулах боломжтой зэргээр стратеги, аюул дарамт хоёрыг шууд холбох замаар завсрын үр дүнг чөлөөт байдлаар гаргаж болно.



Диаграмм. Үр дүнгийн хэлхээний бүдүүвч схем



Хэрэв сонгосон стратегийн хүрээнд гарна хэмээн тооцоолж, таамаглаж буй завсрын үр дүнгүүд нь хамгаалах үнэт зүйлд учирч буй аюул, дарамтыг хангалттай хэмжээнд бууруулж чадахгүй байна гэж үзвэл стратегийн сонголтоо эргэн харж, оновчтой хувилбарыг дахин сонгож гаргаж болно.

Үр дүнгийн хэлхээ нь стратегийн оновчтой байдлыг баталгаажуулахаас гадна урт хугацааны үр дүнд хүргэх богино хугацааны зорилтуудыг тодорхойлоход маш их ач холбогдолтой арга юм.

Зорилт тодорхойлох:


Зорилт нь зорилгодоо хүрэхэд шаардлагатай гэж үзсэн завсарын үр дүнгүүд буюу ирээдүйд гарах өөрчлөлтийг харуулсан үр дүнгийн алхамуудыг тодорхойлсон тодорхойлолт юм. Өөрөөр хэлбэл, гол гол таамаглал, завсрын үр дүнгээ баталгаажуулан тодорхойлж буй хэлбэр юм.

Зорилтоо стратеги тус бүрээр хийсэн үр дүнгийн хэлхээнд дэвшүүлсэн завсрын үр дүн болох таамаглал, аюул, дарамтын өөрчлөгдөх боломжид суурилан тодорхойлж бичнэ. Ингэхдээ дараах зүйлсийг анхаарна уу:

1. Эхний ээлжинд үр дүнгийн хэлхээнд аюул, дарамтыг шууд бууруулахад чиглэсэн зорилтыг тодорхойлохыг хичээх хэрэгтэй. Тухайн үр дүнгийн хэлхээнд хамаарал бүхий аюул, дарамт бүрийг хэлэлцэн шууд бууруулах боломж байгаа эсэх, завсрын үр дүн буюу таамаглалууд нь хэрэгжих боломжтой эсэхийг хэлэлцээд **тухайн аюул, дарамтыг бууруулснаар хүрэхийг хүсэж буй завсарын үр дүнг томъёолон** бичнэ.
2. Зарим тохиолдолд тухайн аюул, дарамтыг шууд бууруулах биш гол шалтгааныг бууруулах буюу таамаглаж буй завсарын үр дүнгүүдийг бий болгох байдлаар зорилт тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл, **гол шалтгаануудыг бууруулах чиглэлээр тодорхойлсон завсарын үр дүнг илэрхийлсэн зорилтуудыг томъёолон** бичиж болно.
3. Үр дүнгийн хэлхээнд зорилтуудыг оруулж ирснээр алхам, алхамаар юунд хүрч, ямар үр дүнг гаргах ёстойг илэрхийлж байгаа тул тухайн стратегийг хэрэгжүүлснээр амжилтад хэрхэн хүрэх, стратеги нь амжилтад хүргэхэд хир зэрэг нөлөөлж болох талаар нэгтгэн харж, хэлэлцээд завсарын үр дүн болох **зорилтуудаа агуулга болоод тооны хувьд эцэслэн тохирох** хэрэгтэй.

Үр дүнгийн хэлхээ хийж, завсрын үр дүн, зорилтоо тодорхойлон хэлэлцэж байх явцад тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагаа тодорхойлогдож гарч ирдэг учраас тухай бүрт нь тэмдэглэж байх нь зүйтэй. Энэ нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах суурь нөхцөл болдог.

Жишээ. Үр дүнгийн хэлхээ буюу дэвшүүлсэн зорилго, зорилтуудын уялдаа холбоо



Сайн томъёолсон зорилтууд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Үр дүнд чиглэсэн:** Нэг буюу хэд хэдэн хамгаалах үнэт зүйлд эсвэл дэвшүүлсэн зорилгод нөлөөлж буй аюул дарамт болон боломжит хүчин зүйлсийн бодит өөрчлөлтийг илэрхийлсэн байх;
2. **Хэмжигдэхүйц:** Тоо, хувь, хэмжээ зэрэг хэмжиж болохуйц тоон холбогдлоор илэрхийлэгдсэн байх;
3. **Хугацаатай:** Хүрэх хугацаа нь тодорхой байх – хэдий хугацааны дараа тухайн үр дүндээ хүрсэн байхаа тодорхой бичсэн байх;
4. **Тодорхой** – Төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож буй бүх хүмүүс ижил ойлголттой байхаар тодорхой томъёологдсон. Өөрөөр хэлбэл хэн ч хараад ойлгохоор тодорхой бичсэн, давхацсан эсвэл хоёрдмол утга илэрхийгээгүй байх;
5. **Хэрэгжихүйц** – Хэрэгжих газар нутгийн хувьд тухайн үеийн төрийн бодлого, нийгэм, санхүү, хүний нөөцийн нөхцөл байдлын хувьд үр дүн гаргах эсвэл хэрэгжүүлэх боломжтой байх.

ЗӨВЛӨМЖ: Зорилтоо оновчтой эсэхийг шалгах

1. SMART буюу сайн томъёологдсон зорилтуудад тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг харах хэрэгтэй.
2. Байгаль хамгаалалд үр дүн гаргахын тулд хир хэмжээний өөрчлөлт хийх, хийхээр төлөвлөж буйгаа тодорхой болгон харах хэрэгтэй.
3. Зорилтоо тодорхойлохдоо одоо байгаа мэдээллийг ашиглах. Энэ нь хэр зэрэг өөрчлөлт хийх шаардлагатай байгааг тодорхойлохын тулд өнөөгийн бодит буюу суурь түвшинг ойлгоход тустай байх болно.
4. Бусад зорилт, стратегийн харилцан хамаарал, нөлөөг ойлгох. Нэг чиглэлийн зорилтууд нь нэг нэгнээсээ логик хамааралтай байх ёстой. Мөн бусад стратегийн хүрээнд дэвшүүлсэн зорилтууд нийлж эцсийн үр дүнд хүрэхэд хамтаараа хувь нэмрээ оруулж болно гэдгийг санах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл стратеги, зорилт тус бүр нь өөр өөрийн онцлогоор завсарын үр дүнг гарган хувь нэмрээ оруулж, эцэстээ бүгд нэгдэж байж менежментийн төлөвлөгөөний эцсийн зорилгыг биелүүлэх учиртай.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Хамгаалах үнэт зүйл тус бүрээр зорилгуудыг тодорхойлсон байна.
- Аюул, дарамтыг үүсгэж байгаа гол асуудал, шалтгааныг тодорхойлон тэдгээрийг бууруулахад чиглэсэн стратегийн хувилбаруудыг гаргаж ирсэн байна.
- Үр дүнгийн хэлхээ хийж сонгосон стратегиэ баталгаажуулах, завсарын үр дүнг урьдчилан таамагласан байна.
- Завсарын үр дүнгүүд болон зорилтоо тодорхойлж тохирсон байна.

2.2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ алхамд менежментийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилго, стратеги, зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн бүрдэлдэхүүн хэсэг нь:

1. Стратегийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын дор хэрэгжүүлэх шаардлагатай багц үйл ажиллагааг төлөвлөсөн ерөнхий төлөвлөгөө байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн нарийвчилсан, жилийн ажлын буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, мөрдөж ажиллана гэдгийг санаж ерөнхий бөгөөд тодорхой төлөвлөнө.

Үйл ажиллагааны болон мониторингийн төлөвлөгөөг сайн төлөвлөсөн байж болно. Гэхдээ төлөвлөгөөг хэрэгжүүлэх механизм буюу нөхцөлийг бүрдүүлэх нь чухал тул дараах хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөний бүрдэлдэхүүн хэсэг болгон холбогдох үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

2. Хүнийнөөцийн төлөвлөгөө: Төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, тэдгээрийн чадавхи болон хүний нөөцийг бий болгох боломжийг үнэлж, түүнд тулгуурлан хүний нөөцийн чадавхийн төлөвлөгөө гаргасан байна. Мөн энэ хэсэгт хамтрагч талуудыг тодорхойлох (ихэнхдээ төлөвлөгөө боловсруулж эхлэх үе шат болон нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж байх явцад хамтрагч болон оролцогч талууд тодорхой болсон байдаг), хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, хэрэгцээ шаардлагыг хамтатган зураглан, хамтын ажиллагааны арга замыг тодорхойлж төлөвлөгөөнд тусгасан байна.
3. Техник, тоног төхөөрөмж, хангамж: Шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бусад шаардлагатай нөөц, хангамжийн үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байна.
4. Санхүүгийн төлөвлөгөө: Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт (төсвийн төсөөлөл), тэдгээрийн одоогийн болон боломжит эх үүсвэрийг тодорхойлсон санхүүгийн төлөвлөгөө гаргасан байна.
5. Эрсдлийн төлөвлөгөө: Эрсдэл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замаа тодорхойлон эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан байна. Эрсдлийн үнэлгээг дараах үндсэн 2 чиглэлд хийж, эрсдлийг бууруулах төлөвлөгөө тусгайлан гаргах, эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөөг эргэн харж болзошгүй эрсдлийг тооцон төлөвлөгөөг сайжруулсан байж болно. Энэ тохиолдолд эрсдлийг хянах шалгуур үзүүлэлтийг мониторингийн төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй. Эрсдэл тооцох чиглэл:
 - a. Үйл ажиллагааг хэрэгжүүлснээр байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэл буюу сөрөг нөлөө бий болох эсэх;
 - b. Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй байгаль, цаг уур, нийгэм, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалттай холбоотой эрсдэл.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь олон хуудас байх шаардлагагүй бөгөөд хүснэгтэн эсвэл схем, диаграммаар илэрхийлсэн энгийн байдлаар бичих нь зүйтэй. Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн жил бүр жилийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө буюу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Үйл ажиллагааны төлөвлөгөө
- Хүний нөөц, санхүүгийн болон бусад нөөц (техник хангамж гэх мэт)-ийн үнэлгээ
- Хүний хөгжил, хамтын ажиллагааны стратеги, төлөвлөгөө
- Санхүүгийн төлөвлөгөө

2.3. МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Менежментийн төлөвлөгөөг бодитой, амьд байлгах гол үндэс нь хэрэгжилтийн явцад үр дүнг тогтмол хянаж байх явдал юм. Иймээс дэвшүүлсэн зорилго, зорилтодоо хүрэх явцыг хянах зорилго бүхий мониторингийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.

Мониторингийн төлөвлөгөө нь менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц, мэдээ баримт, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх цаг хугацаа, төсөв, мөн болзошгүй эрсдлийг тодорхойлж өгдөгөөрөө ач холбогдолтой. Мониторингийн төлөвлөгөө нь менежментэд оролцогч бүх талууд хянаж байхаар нээлттэй байх ёстой.

Мониторингийн төлөвлөгөө боловсруулах алхам:

- 1. Мэдээллийн хэрэгцээг тодорхойлох:** Мониторинг нь санхүүгийн болон хүний нөөцийг хамгийн бага түвшинд ашиглан дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд наад захын найдвартай, шаардлагатай мэдээллээр хангаж өгөх үүрэгтэй. Иймээс мониторингийн төлөвлөгөөг боловсруулах эхний алхам нь зорилго, зорилтын хэрэгжилтийг хянахад шаардагдах мэдээллийн хэрэгцээг тодорхойлох явдал юм. Ингэхийн тулд:
 - Хэнд зориулж мониторинг хийх вэ буюу зорилтот талууд,
 - Тэд юу мэдэхийг хүсч байгааг,
 - Тэдний хэрэгцээг хангах түвшинг тус бүр тодорхойлох хэрэгтэй болно.

Жишээ: Хүснэгт 8. Мониторингийн зорилтот талууд ба тэдгээрийн мэдээллийн хэрэгцээ

Зорилтот талууд	Мэдээллийн хэрэгцээ ба сонирхол
Төлөвлөгөө боловсруулсан болон хэрэгжүүлэх багийн гишүүд, хамтрагч талууд	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байна вэ? - Үр дүнгийн хэлхээ дэх таамаглал зөв байна уу? - Бид зорилгоо цаг хугацаандаа биелүүлж чадаж байна уу? - Төлөвлөгөөг хэрхэн сайжруулах вэ?
Санхүүжүүлэгчид	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байна вэ? - Хүлээгдэж буй үр дүн нь хугацаандаа гарах уу?

Зорилтот талууд	Мэдээллийн хэрэгцээ ба сонирхол
Иргэд болон бусад оролцогч талууд	- Төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байна вэ? - Бидний амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?
Байгаль хамгаалах төрийн байгууллага болон ТББ	- Төлөвлөгөөний зорилго, зорилтууд биелсэн үү? - Байгаль хамгаалалд үр дүн гарсан уу? - Хэрхэн ажилласан бэ? - Юу болсонгүй вэ? Яагаад?
Судлаач, эрдэмтэд	- Юу болоод, юу болохгүй байна? Яагаад?
Аудитор, эрх бүхий байгууллагууд	- Төлөвлөгөө нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх? - Сайн туршлагыг нэвтрүүлэх боломжтой эсэх?

2. Шалгуур үзүүлэлт тодорхойлох: Шаардлагатай мэдээллийн хэрэгцээг хангахад шаардагдах өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд ашиглах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох явдал чухал. Шалгуур үзүүлэлт нь зорилго, зорилтын хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр тодорхойлогдсон чанарын болон тоон үзүүлэлт байх ба дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:

1. *Хэмжигдэхүйц* - тоо, хувь, хэмжээ зэрэг хэмжиж болохуйц тоон холбогдлоор илэрхийлэгдэх боломжтой;
2. *Тогтвортой, тодорхой* - олон салаа утга агуулаагүй, тодорхой нэг зүйлийг тогтвортойгоор хянах, хэмжих боломжтой;
3. *Өөрчлөлтөд мэдрэг* - орчны нөхцөлийг даган өөрчлөгддөг, тэр нь мэдрэгддэг байх буюу богино хугацаанд өөрчлөлт нь илэрдэг;
4. *Хэрэгжихүйц* - хэмжихэд хялбар, өртөг бага зарцуулдаг, тогтмол хэмжих боломжтой;
5. *Хамааралтай* - үр дүн буюу зорилго, зорилтод шууд хамааралтай байх.

Нэгээс дээш тооны шалгуур үзүүлэлт сонгох нь үр дүнг олон талаас бодитойгоор үнэлж дүгнэх боломжийг олгодог тул дээрх мэдээллийн хэрэгцээт асуулт, зорилго, зорилт тус бүрт 2 ба түүнээс дээш тооны шалгуур үзүүлэлт сонгох хэрэгтэй.

Зорилгын түвшинд шалгуур үзүүлэлт сонгохдоо хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээг эргэн харах ба тэнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг шууд ашиглах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг хянах нь:

Уур амьсгалын өөрчлөлтийн тодорхой бус нөлөөнөөс хамааран түүнд чиглэсэн стратегийн үр дүнгийн мониторинг тодорхойгүй байх тохиолдол их бий. Ийм нөхцөлд эргэлзээг багасгах зорилгоор мониторингийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээг тусган төлөвлөх нь чухал. Төлөвлөсөн арга хэмжээ ба шалгуур нь уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэг байх, экологийн нөлөөлөл мэдрэгдэхүйц, эсвэл бусад дасан зохицох стратегийн үр дүнгийн хамт илэрхийлэгдэхээр байж болно.

3. Арга зүй сонгох: Шалгуур үзүүлэлтийг тодорхойлсны дараа хэрхэн хэмжиж байх талаар бодох хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, ямар арга ашиглах вэ?

Арга зүй нь шалгуур үзүүлэлтийг хэмжихийн тулд өгөгдөл цуглуулахад ашигладаг тодорхой нэг арга барил бөгөөд дараах шалгуурт нийцсэн байвал зохино. Үүнд:

1. *Үнэн зөв* - өгөгдөл цуглуулах арга зүй нь алдаа бага эсвэл огт алдаагүй байх;
2. *Найдвартай* - үр дүн нь тогтмол давтагдах боломжтой - аргыг ашиглах бүрт ижил төрлийн үр дүн гардаг байх;
3. *Зардал багатай* - арга зүй нь өгөгдөл цуглуулах, боловсруулахад хэт их зардал шаарддаггүй, төсвийн нөөц боломжид нийцсэн байх;
4. *Хэрэгжихүйц* - арга зүйг багийн гишүүд ашиглах боломжтой байх;
5. *Тохиромжтой* - тухайн газар нутгийн соёл, нийгэм, биологийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч нийцүүлсэн байх.

Хамгийн чухал нь менежментийн хэрэгцээг хангахуйц найдвартай өгөгдөл өгөх хамгийн зардал багатай аргыг сонгох явдал юм.

Шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг хянахын тулд заавал өөрсдөө мэлээлэл цуглуулах шаардлагагүй байж болно. Тухайлбал, хамгаалахаар сонгосон үнэт зүйлийн нэг болох загасны популяцийн талаархи мэдээллийг цуглуулах шаардлагатай тохиолдолд газар дээрээ судалгаа хийх өртөг өндөр, эсвэл хүний нөөцийн боломжгүй байж болно. Тэгвэл өртөг багатайгаар шийдэх нэг арга нь “төрийн эсвэл судалгааны байгууллагуудын албан ёсоор мэдээлсэн эсвэл нэгтгэн цуглуулсан мэдээ, бүртгэлийг татаж авч” ашиглаж болно. Өөрөөр хэлбэл, бусад баталгаат эх үүсвэр байгаа бол шууд ашиглахаар тооцох нь зүйтэй. Ингэснээр зарцуулах төсвийг бууруулах болно.

Мэдээлэл байхгүй бөгөөд нөхөж орлуулах боломжгүй тохиолдолд анхан шатны мэдээлэл цуглуулах шаардлагатай болох ба энэ тохиолдолд холбогдох ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, санхүүгийн төлөвлөгөөнд мониторинг хийхэд зайлшгүй шаардагдах төсвийг урьдчилан тооцож төлөвлөх хэрэгтэй.

Мониторингийн төлөвлөгөөний загвар: Мониторингийн төлөвлөгөөний загвар нь тухайн сонгосон шалгуур үзүүлэлт, тэдгээрийн нарийвчлал, онцлог, арга зүйгээс хамааран өөр өөр байх боломжтой боловч нэгдсэн байдлаар дараах загвар асуулгын хүрээнд ерөнхий төлөвлөгөө гаргаж болно. Үүнд:

- Зорилго, зорилт, хэрэгцээт мэдээллийн чиглэл
- Шалгуур үзүүлэлт
- Хэмжих нэгж
- Хэмжих хугацаа (хир хугацаанд ямар давтамжтай хийх)
- Хариуцах эзэн (мэдээлэл цуглуулах болон боловсруулан дүн шинжилгээ хийх хүмүүс)
- Арга зүй
- Мэдээллийн эх сурвалж

- Суурь түвшин (Суурь түвшин нь зорилт, арга хэмжээ эхлэх үеийн, эсвэл эхлэхээс дөнгөж өмнөх үеийн байдлын талаарх тоон болон чанарын мэдээлэл юм. Ирээдүйн гүйцэтгэлийг хэмжих эхлэлийн цэг, эсвэл чиглүүлэгчээр суурь түвшинг хэрэглэдэг)
 - Хүрэх түвшин (Шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшний мэдээлэл цуглуулсны дараах алхам бол үр дүнд хүрэх үүднээс тодорхой цаг хугацаанд ямар ахиц өөрчлөлтөд хүрч болох буюу үр дүнгийн хүрэх түвшинг тогтоох асуудал юм. Энэ нь үр дүн болох зорилго, зорилт, *шалгуур үзүүлэлт, суурь түвшинд үндэслэнэ*. Үр дүнгээ илүү нарийвчилахын тулд он оноор төлөвлөж болно)
 - Шаардагдах төсөв
 - Хэрэглээний түвшин буюу мэдээллийг хэн хэрхэн хэрэглэх вэ?
- Мөн тайлагнах арга зам, хугацаа үүнд хамаарна.

Мониторингийн төлөвлөгөөг хүснэгтэн байдлаар хийх эсвэл тодорхой нэг программ хангамж ашиглаж болно. Гэхдээ зайлшгүй нэгдсэн мэдээллийн сан үүсгэн, тогтвортой байдлыг ханган ажиллах хэрэгтэй.

ЭНЭ ШАТАНД ГАРАХ ҮР ДҮН:

- Мониторинг хийх шаардлагатай мэдээллийн жагсаалт гаргасан байна.
- Шалгуур үзүүлэлт ба арга зүйг тодорхойлсон байна.
- Эцэслэн боловсруулсан мониторингийн төлөвлөгөө.
- Бэлэн болсон менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна.

ЗӨВЛӨМЖ: Менежментийн төлөвлөгөө бичих арга барил, хэлбэр

Менежментийн төлөвлөгөөг олон нийт, мэргэжлийн бус хүн ойлгохоор, шинжлэх ухааны нарийн нэр томъёо хэрэглэхээс зайлсхийсэн, ТХГН-ийн үнэ цэнэ, ач холбогдлыг хүн бүрт хүргэсэн, түүний хэрэгжилтэд олон нийтийн дэмжлэг авахуйц хэлбэрээр бичигдсэн байх хэрэгтэй. Сайн менежментийн төлөвлөгөө нь дараахь шинж чанарыг агуулсан байвал зохино. Үүнд:

- Тодорхой бөгөөд хүн бүрт ойлгомжтой;
- Товч, мэдээлэл сайтай, агуулга нь асуудлаа бүрэн дүүрэн хамарсан;
- Нягт нямбай боловсрогдсон, тодорхой зорилго, зорилтууд дэвшүүлсэн;
- Системтэй, логик дэс дараатай байх;
- Оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрсөн, тэднийг уриалан дуудсан шинжтэй;
- Бодитой, хэмжиж болохуйц зорилго, зорилтуудтай, түүндээ хүрэх арга зам нь тодорхой, үр дүнд нь хяналт шинжилгээ-мониторинг хийх боломжтой;
- Асуудалдаа төвлөрсөн, үр өгөөжтэй;
- ТХГН-ийн зохистой менежментийн арга хэрэгсэл болох чиг үүргээ хэрэгжүүлсэн байх зэрэг болно.



ТОДОРХОЙЛОХ



ТӨЛӨВЛӨХ



ХЭРЭГЖҮҮЛЭХ



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ,
УЯЛДУУЛАХ



ҮР ДҮНГ
ХУВААЛЦАХ





ХЭРЭГЖҮҮЛЭХ

Энэ нь өмнөх үе шатанд хамтын оролцоотойгоор боловсруулан баталгаажуулсан менежментийн төлөвлөгөөг газар дээрээ хэрэгжүүлэх, төлөвлөсөн үр дүндээ хүрэх хамгийн чухал үе шат юм. Түүнчлэн 3 ба 4 дэх үе шат зэрэгцэн ижил хугацаанд хэрэгждэгээрээ өмнөх үе шатуудаас ялгаатай.

Энэ үе шатанд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх жилийн ажлын нарийвчилсан буюу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахын зэрэгцээ, хэрэгжилтийг хангахад шаардагдах бүхий л нөөц, боломжийг дайчлах юм. Хэрэгжүүлэх үе шат нь тасралтгүй үргэлжлэх, зэрэгцэн хэрэгжих дараах үндсэн 3 алхамаас бүрдэнэ. Үүнд:

3.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

3.2 Хүний нөөцийн чадавхи бэхжүүлэх

3.3 Төсөв, санхүүжилтийг шийдвэрлэх

3.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

Төлөвлөх үе шатанд стратеги тус бүрийн дор хэрэгжих менежментийн үйл ажиллагааг ерөнхий байдлаар төлөвлөн гаргасан. Харин энэ алхамд эдгээр ерөнхий төлөвлөгөөг илүү нарийвчлалтайгаар хэрэгжүүлэх түвшинд болгон төлөвлөх юм. Энд менежментийн төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэх багийн гишүүд хамтрагч талуудтайгаа хамтран холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргана. Хугацааны хувьд 1 жилээр төлөвлөх бөгөөд энд **үйл ажиллагааны болон мониторингийн төлөвлөгөө** аль аль нь багтана. Агуулгын хувьд дараах байдалтай байна. Үүнд:

- Менежментийн төлөвлөгөөнд төлөвлөсөн ерөнхий үйл ажиллагааны хүрээнд яг ямар ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй байна вэ?
- Хэн энэ ажлыг хариуцах вэ?
- Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд хэн туслах боломжтой вэ?
- Төлөвлөгдсөн ажлууд хэзээ хийгдэж дуусах вэ?
- Тухайн ажлыг хийж дуусгахад хэр хэмжээний хөрөнгө, санхүүжилт хэрэгтэй вэ? Төсөв байгаа эсэх? Олох шаардлагатай юу, боломж бий юу?
- Гүйцэтгэж буй арга хэмжээний чанар, үр дүнг хэрхэн хянах вэ?
- Ямар нэгэн эрсдэл үүсэх үү?
- Техник хэрэгсэл, хүний нөөцийн чадавхи бэхжүүлэх шаардлага, хэрэгцээ, түүний хүрээнд юу хийх вэ?

Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчны хүрээнд төлөвлөгөө боловсруулахад тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг хангасан байх;
2. Менежментийн төлөвлөгөөний зорилт, стратеги, үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцүүлэн төлөвлөх;

3. Тухайн жилийн улс, бүс нутаг, орон нутаг, салбарын бодлогын уялдааг хангах;
4. Байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Гүйцэтгэлийн (жилийн ажлын нарийвчилсан календарчилсан) төлөвлөгөө бэлэн болсон байна.

3.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чухал нөхцөл бол хэрэгжүүлэх багийн хамтын ажиллагаа, ур чадвар байдаг. Иймээс менежментийн төлөвлөгөөний хүрээнд энэ жилд хэрэгжүүлэх сургалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана. Ингэхдээ багаараа ярилцаж “ямар төрлийн сургалт хэнд хэрэгтэй вэ” гэсэн хэрэгцээгээ нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. Хамтдаа ярилцахдаа дараах зарчмыг баримталж ажиллах нь хэрэгцээгээ бодитойгоор гаргахад тустай. Үүнд:

- Стратеги тус бүрээр ярилцах;
- Багийн гишүүд тус бүрээр ярилцах;
- Менежмент, удирдлагын чиглэлээр ярилцах;
- Төсөл бичих, санхүүжилтийн чиглэлээр хэлэлцэх;
- Ажлын нөхцөл байдлаас шалтгаалан хамтрагч талуудаа чадавхижуулах хэрэгцээ гарч ирэхийг үгүйсгэхгүй. Тиймээс хамтрагч талуудтайгаа хамтдаа суралцах сургалтын төлөвлөгөө гаргах нь зүйтэй.

Хамтрагч талууд:

Байгаль хамгааллын нэг байгууллага менежментийн төлөвлөгөөгөө бие даан хэрэгжүүлэх дотоод нөөц боломж, туршлага хангалтгүй хязгаарлагдмал ба улмаар дангаараа амжилт гаргах боломжгүй байдаг тул хамтран ажиллах байгууллага, хувь хүн, нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэх асуудал чухал юм. Тиймээс менежментийн төлөвлөгөөнд тодорхойлогдсон хамтран ажиллагч талууд, хамтын ажиллагааны чиглэл, хамтран хэрэгжүүлэх ажлаа нарийвчилан гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулна. Хамтын ажиллагааг өрнүүлэх, бэхжүүлэх чухал арга зам бол бүхий л шатанд оролцоог хангах явдал юм. Талуудын оролцоог хангах чиглэлээр дараах энгийн хялбар аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

- Оролцогч талуудын оролцооны хэлбэр, зорилгыг нь тодорхой болгон нэгдсэн ойлголтод хүргэх уулзалт хийх;
- Хамтрагч талуудын саналыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;
- Зөвлөгөөг нь авах;
- Мэдээллээ тогтмол хуваалцаж байх;

- Гол хамтрагчтайгаа хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах, хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган харилцан баталгаажуулах;
- Хамтрагч талуудаа идэвхижүүлэх арга хэрэглэх (сургалт, үйл ажиллагаанд тогтмол урих, хамтарсан урлаг соёл, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах гэх мэт)
- Дэмжлэг хүсэх;
- Ажлын үр дүнд мониторинг хийхдээ хамтрах, нээлттэй байх.

Ажлаа хэрэгжүүлэхээсээ өмнө албан ёсны ажлын хэсэг байуулан хамтын ажиллагааны чиглэлээ талуудтайгаа тохиролцон тодорхой болговол илүү ажил хэрэгч үүднээс хандаж байгаагийн илрэл юм. Сайн хамтын ажиллагааг бий болгоход дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Оролцогч талуудын төлөөллөө нягтлах, төлөвлөгөөнд хамтарч ажиллах шаардлагатай хамтрагч талыг орхигдуулсан бол нэмж оруулах;
- Талуудтай найрсаг харилцаатай байх, тэдний ашиг сонирхлыг харгалзан үзэж байх;
- Хэрэв менежментийн төлөвлөгөөний зорилготой нийцэхгүй байгаа тохиолдолд хамтын ажиллагаагаа эргэн харж хамтрах үгүйгээ шийдвэрлэх;
- Хамтрагч талууд ажил хийхээр хариуцан авсан бол ажил хэрэгч байдлаар тэдний ажлыг дүгнэж байх. Сайн хэрэгжүүлсэн тохиолдолд урам өгөх, бусад хамтрагч талуудад хийсэн ажлын үр дүнг нь танилцуулж байх;
- Талуудтай хамт ажил хийж байхдаа өөрсдийн нөөц бололцоогоор дэмжлэг үзүүлэх;
- Менежментийн төлөвлөгөөний үр дүнгийн мониторинг хийхдээ хамтрах, асуудлаа нээлттэй танилцуулах, хэлэлцэх,
- Хэрэв хамтрагчийн зүгээс алдаа, дутагдал, сайжруулах шаардлагатай зүйл гаргавал зөрчил үүсгэхгүйгээр тайлбарлан харилцан ойлголцох.

ЭНЭ ШАТАНД ГАРАХ ҮР ДҮН:

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх баг, багийн гишүүдийн ажил үүргийг нь тодорхой болгосон байна.
- Гол оролцогч талуудыг өөрсдийн ажилдаа татан оролцуулсан байна.
- Мэдээллийг хамтрагч талуудтай хуваалцаж байх механизмыг бий болгосон байна.
- Талуудтай хамтран ажиллах албан ёсны уулзалт болон баримт бичиг хийгдсэн байна.
- Хүний нөөцийг чадавхижуулах төлөвлөгөө гарч хэрэгжсэн байна.

3.3. ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ

Менежментийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд санхүүгийн бэрхшээлүүд тулгардаг бөгөөд үүнээс хамааран зөвхөн төлөвлөөд орхидог арга барилыг өөрчлөх шаардлагатай. Нэмэлт санхүүжилтийг эрэлхийлэн олж, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахын тулд:

- Менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажлаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэрэгцээтэй байгаа санхүүгийн тооцоогоо нарийвчилан гаргах;
- Өөрсдийн нөөц (Хамгаалалтын захиргааны боломж) бололцоогоо тооцоолох;
- Төсөв санхүү босгох гэдэг нь заавал мөнгө олох гэсэн үг биш тул бусад эх сурвалжийг эрэлхийлэн тооцоолно. Зарим ажлуудыг ижил чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, орон нутгийн удирдлагуудтай хамтран тэдгээрийн ажлын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг хангуулах замаар хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Жишээ нь: Эргүүл хяналт хийх зардал хүрэлцэхгүй



байгаа тохиолдолд аймаг, сумын тамгын газар, байгаль орчны тасагтай хамтран тэдний ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хамтдаа эргүүл хийж болно. Булаг, ус, ургамлын судалгаа хийхээр төлөвлөсөн бол аймгийн УЦУОШГ-тай хамтран тэдний хийж буй судалгаатай уялдуулан зарим судалгааны цэгүүдийг нь өөрсдийн хэрэгтэй байгаа газар, цэгүүд дээр хийлгэхээр ярилцан тохиролцож болно;

- Ийнхүү дээрх 3 чиглэлийг нэгтгэн тооцоолсны дүнд зайлшгүй шаардлагатай байгаа санхүүжилтийн дүн, түүнд хамаарах ажлын агуулга, чиглэлийг тодорхойлон гаргах шаардлагатай;
- Дутагдаж буй санхүүжилтийг нөхөх төслийн товч санал боловсруулах хэрэгтэй;
- Төслийн товч саналаа өгөх, санхүүжүүлэгч олохын тулд боломжит санхүүжүүлэгчдийн нэрсийн жагсаалт гарган, тэдгээрийг эрэмбэлж эхнээс нь холбогдох байгууллагуудтай уулзан өөрсдийн ажил, юу хийх, юунд хүрэхийг зорьж байгаагаа танилцуулан төслийн саналаа өгөх;
- Мөн хөрөнгө татах зорилгоор сурталчилгааны кампанит ажлыг бусад талуудтайгаа хамтран зохион байгуулах зэргээр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд тасралтгүй хүчин чармайлт гарган ажиллах хэрэгтэй.

ЭНЭ ШАТАНД ГАРАХ ҮР ДҮН:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв илүү нарийн тодорхойлогдсон байна.
- Боломжит санхүүгийн эх үүсвэр, хамтран ажиллах талууд тодорхой болсон байна.
- Шаардлагатай санхүүжилтийг бий болгох төслийн санал боловсруулагдсан байна.
- Дэмжлэг үзүүлж болох байгууллага, иргэн, нутгийн иргэдийн байгууллага, ТББ, ААН, байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгох уулзалт, хэлэлцүүлэг хийх, хамтарсан кампанит ажил зохион байгуулах зэрэг хөрөнгө босгох санаачилгуудыг гарган хэрэгжүүлсэн байна.
- Бодит санхүүгийн дэмжлэг, хамтран ажиллах талууд тодорхой болсон байна.



ТОДОРХОЙЛОХ



ТӨЛӨВЛӨХ



ХЭРЭГЖҮҮЛЭХ



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ,
УЯЛДУУЛАХ



ҮР ДҮНГ
ХУВААЛЦАХ





ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, УЯЛДУУЛАХ

Энэ үе шатын үндсэн зорилго нь менежментийн төлөвлөгөөний хүрээнд хамаарах бүхий л мэдээ, баримт, өгөгдлийг нэгтгэн дүн шинжилгээ хийж хэрэгцээт мэдээлэл болгон хувиргахад оршино. Энэ үе шат нь дараах алхамуудаас бүрдэнэ. Үүнд:

- 4.1. Мэдээ, баримт, өгөгдлүүдийг нэгтгэн цуглуулах, мэдээллийн сан үүсгэх;
- 4.2. Үр дүнг шинжлэх, мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;
- 4.3. Төлөвлөгөөг сайжруулах эсвэл шинэчлэх.

Үнэлгээ нь төлөвлөлтийн чухал үе шатын нэг бөгөөд дараах давуу талтай. Үүнд:

- Өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж гаргана;
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг гаргана;
- Талуудын оролцоог нэмэгдүүлнэ;
- Дараагийн шатны төлөвлөлтийн гол агуулга, санаа, үйл ажиллагааг тодорхойлно;
- Дараагийн шатны үнэлгээний суурь, дүгнэлт гаргах гол үзүүлэлт, үндэслэл болдог.

Үнэлгээний арга зүй нь системийн, тодорхой нэг зорилгод чиглэсэн (тухайлбал, зөвхөн ямар нэгэн аюул, дарамтыг үнэлэх, санхүүгийн гэх мэт) эсвэл зөвхөн тухайн ТХГН-т хамааралтай гэх мэт хамрах хүрээ, зорилгоосоо хамааран өөр өөр байдаг. Үнэлгээнээс юу олж мэдэхийг хүсч байгаа талаар тодорхой ойлголттой байх нь чухал бөгөөд түүнд нийцүүлэн арга зүйг сонгодог. Ерөнхий утгаараа үнэлгээ нь асуулт-хариулт гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг ба харилцан адилгүй асуултад хариулт өгөх “бүгдэд таардаг” үнэлгээний загвар, аргачлал гэж байхгүй. Тиймээс төлөвлөлтийн үйл явцын хүрээнд хэд хэдэн үнэлгээний арга зүйг ашиглах нь тохиромжтой.

Монгол улсын ТХГН-ийн хувьд дараах төрлийн үнэлгээг хийж байна. Үүнд:

1. *Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт, үнэлгээ:* Жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг талуудын оролцоотойгоор, энэхүү арга зүй болон холбогдох журам (Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралт)-ын дагуу хийнэ. Энд мониторингийн төлөвлөгөө гол суурь болж ашиглагдана.
2. *Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ:* Энэ үнэлгээг батлагдсан арга зүйн дагуу 2 жил тутам хийж байна (Менежментийн төлөвлөгөөний арга зүйтэй уялдсан бөгөөд гол үр дүнг үнэлэхээс

гадна гадаад хүчин зүйлийг хамтад нь үнэлдэг тул тухайн ТХГН-аас гадна үнэлгээний үр дүнг нэгтгэх замаар системийн хүрээнд дүгнэлт гаргахад ашиглах боломжтой байдаг).

3. **Зорилтот үнэлгээ:** Аудит, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын үнэлгээ гэх мэт тодорхой нэг чиглэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн үнэлгээ байна.
4. **Олон нийтийн:** Энэ үнэлгээг хамтрагч талуудын санал санаачилгад тулгуурлан хийж болно. Арга зүйн сонголт нь зорилгоосоо хамаарч төрөл бүрийн хэлбэртэй байж болно.

Үнэлгээг тогтмол хийж төлөвлөлт, үйл ажиллагаа, төсөвт тодотгол оруулах үндэслэл болгон ашиглана.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг дэвшүүлсэн зорилго, зорилт, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу талуудын оролцоотойгоор тогтмол үнэлж дүгнэж байх нь хэрэгжилт хэр үр дүнтэй байгааг, дэвшүүлсэн зорилго, зорилтодоо хүрэхийн тулд юу хийх шаардлагатайг тодорхойлох боломжийг олгодог чухал алхам юм. Аль ч төрлийн үнэлгээ нь асуулт-хариулт гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд хариулт өгөх гол суурь нь мэдээлэл байна. Үнэлгээний гол асуултад хариулахын тулд мэдээлэл өгч буй хүмүүс мэдээллийн хэрэгцээг мэдэж байх хэрэгтэй. Тавьж буй асуулт болон хариулж буй мэдээлэл хооронд зөрүүтэй байж болохгүй. Тиймээс мэдээллийн сан бүрдүүлж, тогтмол баяжуулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг тогтмол хянаж байх шаардлагатай байдаг. Энэ үе шат нь бусад бүх үе шаттай хамт, зэрэгцэн хэрэгждэгээрээ онцлогтой.

4.1. МЭДЭЭ, БАРИМТ, ӨГӨГДЛҮҮДИЙГ НЭГТГЭН ЦУГЛУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ

Ямар төрлийн мэдээллийг юуны тулд? хэзээ? хэрхэн (хэн цуглуулах, ямар арга замаар цулгуулах, нэгтгэн дүгнэх вэ)? гэх мэт чухал асуултууд гарч ирнэ.

Ямар төрлийн мэдээлэл юуны тулд? Байгаль орчин, нийгэм, эдийн засаг, менежментийн төлөвлөгөөнд сонгогдсон хамгаалах үнэт зүйл, тэдгээрт учирч буй аюул, дарамтын төлөв байдлын өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд ашиглах үндсэн суурь материал нь холбогдох мэдээ, баримт, өгөгдөл, тэдгээрийг нэгтгэсэн мэдээллийн сан байдаг. Иймээс цаг хугацааны хувьд хязгаарлахгүйгээр, менежментийн төлөвлөгөө хэрэгжиж буй тухайн газар нутагт хамааралтай шаардлагатай бүхий л мэдээ, баримт, өгөгдлийг байнга цуглуулж, мэдээллийн сан үүсгэн түүнд дүн шинжилгээ хийж байх шаардлагатай болно.

Хэзээ, хэрхэн? Төлөвлөгөө боловсруулах үеэс эхлэн мэдээллийн сангийн зөв, оновчтой бүтэц, системтэй байх шаардлагатай. Үүнийг мониторингийг төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллана. Өөрөөр хэлбэл, мэдээ, баримт, өгөгдлийг цуглуулах, нэгтгэн сан үүсгэх үйл явц нь дасан зохицох менежментийн бүхий л алхам, үе шатанд байнга хийгдэж байх ёстой ажил юм.

ЗӨВЛӨМЖ: Цаг хугацааны хязгаар

Нэг л хугацаанд хамаарах дан ганц мэдээ, баримт, өгөгдөл нь хамгаалах үнэт зүйлийн төлөв байдлын өөрчлөлт, ирээдүйн чиг хандлагын талаар дүн шинжилгээ хийх үндэслэл болохгүй. Тиймээс цаг хугацааны хувьд хязгаарлахгүйгээр өмнөх буюу түүхэн мэдээ, баримт, өгөгдлийг мэдээллийн сандаа нэгтгэн цуглуулах шаардлагатай. Ийнхүү өөр өөр цаг хугацаанд хамаарах нэг төрлийн мэдээ, баримт, өгөгдлийг харьцуулах замаар төлөв байдал сайн эсвэл муудсан гэсэн дүгнэлт гаргах боломжтой болдог. Жишээлбэл: “2015 оны судалгаагаар тус ТХГН-т 200 халиун буга тоологдсон” гэсэн нэг цаг хугацаанд хамаарах нэг төрлийн нэг мэдээ зөвхөн тухайн үеийн нөхцөл байдлыг илэрхийлж байгаа болохоос биш тоо толгой өссөн эсвэл буурсан гэсэн аливаа дүгнэлт гаргах боломжийг олгохгүй. Харин 1990 оны судалгаагаар тус ТХГН-т 350 гаруй халиун буга тоологдож байсан гэсэн өмнөх үеийн мэдээ байвал түүнтэй харьцуулан тоо толгой сүүлийн 25 жилийн хугацаанд буурсан байна гэсэн дүгнэлтийг гаргах боломжтой болж байна. Өмнөх цаг хугацаанд хамаарах мэдээ байхгүй байлаа ч тухайн цагт хамаарах нэг мэдээ, баримт, өгөгдлийг эх сурвалж, хугацааны хамтаар мэдээллийн сандаа нэгтгэн хадгална. Энэ нь ирээдүйд буюу тодорхой хугацааны дараа ашиглах суурь нөхцөл буюу мэдээ болох тул мөн үнэ цэнэтэй байдаг.

Хүснэгт 12:
Мэдээллийн сангийн төрөл

Мэдээ, баримт, өгөгдлийн төрөл	Жишээ: Эх сурвалж	Мэдээллийн сан
Тоон – тоон хэлбэрээр илэрхийлэгдэж болох мэдээ, баримт, өгөгдөл хамаарах ба тасралтгүйгээр тогтмол эсвэл, тодорхой хуваарийн дагуу давтамжтайгаар хэмжиж гаргасан байна. Мөн тодорхой, ангилал, бүлгээр ялгасан байж болно.	Амьтны тоо толгой, трансектийн тоо, хууль бус агнуурын тоо, төрөл, мал, өрхийн тоо, ирсэн жуулчдын тоо, оролцогч талуудаас ирүүлсэн саналын тоо гэх мэт	Цаасан бүртгэл (Microsoft word), энгийн хүснэгтэн байдлаар (Microsoft excel, access) үүсгэсэн байх ба эсвэл онлайн серверт (Биосан) сан үүсгэн хадгалсан байж болно. Мөн Miradi программ ашиглаж болно.
Чанарын – тоон хэлбэрээр илэрхийлэх боломжгүй мэдээ, баримт, өгөгдөл	Оролцогч талууд эсвэл ямар нэгэн зорилтот бүлгүүдтэй хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн түүхүүд. Тухайлбал, жендерийн эсвэл төрөл бүрийн сэдвээр асуудал хөндөн ярилцсан байж болно.	Цаасан бүртгэл (Microsoft word), дүрстэй болон дууны бичлэг бүхий файлууд.

Мэдээ, баримт, өгөгдлийн төрөл	Жишээ: Эх сурвалж	Мэдээллийн сан
Орон зайн – газарзүйн координат (ихэвчлэн тоон шинж чанартай боловч чанарын хувьд байж болно) –тай холбоотой мэдээ	Хууль бус агнуур гарсан газрын байршил / солбицол – GPS цэг, ТХГН-ийн хилийн цэс, дотоод бүсийн хил – цэгэн болон талбай.	Хэвлэж гаргасан газрын зураг, Газарзүйн мэдээллийн систем буюу Arc CIS, QGIS гэх мэт программууд ашиглан үүсгэсэн байна.
Санхүүгийн – Санхүүгийн талаарх тоон болон бусад мэдээ	Санхүүгийн бүртгэл, төслийн үйл ажиллагааны хувьд хамааралтай мэдээлэл.	Хүснэгтэн байдлаар (Microsoft excel) үүсгэсэн байх эсвэл холбогдох санхүүгийн програм (ACCPAC эсвэл QuickBooks зэрэг програм) ашигласан байна.
Зураг – зурмал эсвэл фото зураг	Тодорхой нэгэн цэгт ажиглалт хийх зорилгоор авсан өмнө ба дараах байдал гэсэн фото зургууд, үйл ажиллагаанд оролцогчдын зураг, нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммын зураг зэрэг байж болно.	Зургийн цомог, слайд файл, компьютер дэх файлын хавтас, зургийн сан үүсгэдэг тусгай програм хангамж байж болно.
Дүрс болон дууны бичлэг – кино, шторк, дууны бичлэг	Оролцогч талуудтай хийсэн уулзалт, хурлын бичлэг, зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажил, арга хэмжээний бичлэг, хийсэн кино, клип, богино хэмжээний сурталчилгааны шторк	Видео номын сан, компьютерийн файлын хавтас, архивын програм хангамж байх боломжтой. Мөн youtube-д хуудас үүсгэн цахим байдлаар сан үүсгэсэн байж болно.
Мета - бусад төрлийн мэдээ; бичиг баримт	Бүх мэдээллийн сангуудын жагсаалт, мэдээллийн санд байгаа мэдээ, баримтын тодорхойлолт, зургийн цомог дахь зургийн талаархи мэдээлэл	Цаасан жагсаалт, хүснэгтэн хэлбэрээр үүсгэсэн файл гэх мэт

Мэдээллийн сангийн бүртгэл, хадгалалт, боловсруулалт хийхэд зориулагдсан тохиромжтой арга хэрэгсэл, систем буюу мэдээллийн санг хэн, хэрхэн, юуг үндэслэн баяжуулж, хянаж байх нэгдсэн журамтай байх шаардлагатай¹. Үүнд эх мэдээ, баримт, өгөгдлийг системтэйгээр цуглуулах, шалгах, шаардлага хангасан эсэхийг хянах, хуучин мэдээ, өгөгдлийг хэрхэн нэгтгэх, бүх мэдээ, өгөгдлийг системтэйгээр хадгалах зэрэг үйл явц бүгд орно. Энэ нь програмын (компьютерийн ямар нэгэн төрлийн програм хангамж ашиглан мэдээллийн сан үүсгэх), үйл ажиллагааны болон санхүүгийн зэрэг бүх түвшинд хийгдэх ёстой.

¹ Мэдээллийн сан бий болгон ажиллах дотоод журмаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р бүлэг (Байгаль орчны мэдээллийн сан)-т заасан шаардлагыг баримтлан, түүний хүрээнд өөрийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулах боломжтой.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, дүн шинжилгээ хийхэд шаардагдахуйц мэдээллийн сан төрөл тус бүрээр үүссэн байна.
- Мэдээллийн сангийн тогтмол үйл ажиллагааг хангах журам гарч хэрэгждэг болсон байна.

4.2. ҮР ДҮНГ ШИНЖЛЭХ, МЭДЭЭ, БАРИМТАД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Арга зүйн чухал бөгөөд давуу талуудын нэг бол оролцогч талууд хамтран менежментийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилго, зорилтодоо хүрэхийн тулд үйл явц, үр дүнг тогтмол үнэлж, хянаж байх боломжийг олгодог явдал юм. Үүний тулд төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх явцад бий болсон мэдээллийн сан дахь мэдээ, баримт, өгөгдөлд дүн шинжилгээг тогтмол хийж байна. *Дүн шинжилгээ хийх гэдэг нь төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад цуглуулсан эх мэдээ, баримт, өгөгдлийг ашигтай буюу хэрэгцээт мэдээлэл болгон хувиргах үйл явц юм.*

Цуглуулсан мэдээ, баримт, өгөгдөл буюу мэдээллийн сан нь дараах боломжийг олгодог:

- Үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээр хүлээгдэж буй завсрын үр дүнд хүрч чадсан эсэх, урт хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилтодоо хүрэх замдаа байгаа, эсвэл хазайсан эсэхийг мэдэхийн тулд дүн шинжилгээ хийхэд **шаардагдах мэдээллээр хангах;**
- Менежментийн төлөвлөгөө хэрэгжих хугацаанд ямар стратеги, үйл ажиллагаа нь яагаад амжилтад хүрч, мөн яагаад амжилтгүй болсныг тодорхойлох. Өөрөөр хэлбэл **амжилт, сургамжийг тодорхойлох;**
- Төлөвлөгөө боловсруулах үед дэвшүүлсэн **таамаглал нь бодит байдалд нийцэж байгаа эсэхийг харах** зэрэг болно.



Эдгээр нь менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн сайжруулах эсвэл шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх, түүний үндэслэлийг гаргаж өгдөгөөрөө мөн чухал ач холбогдолтой.

Төлөвлөгөө хэрэгжүүлэх явцад маш их мэдээ, баримт цуглуулсан байдаг боловч тэдгээрийг бүгдийг нь боловсруулан дүн шинжилгээ хийж хэрэгцээт мэдээлэл болгон хувиргахад цаг хугацаа, хөрөнгө хүч их зарцуулах шаардлагатай болдог. Иймээс энэ алхамын явцад зарим цуглуулсан мэдээ, баримтуудыг боловсруулалгүй, ашиглахгүйгээр үлдээх тохиолдол их гардаг. Гэхдээ бүх мэдээ, баримт, өгөгдлийг нэгтгэн боловсруулахад анхаарах бус дүн шинжилгээ хийх хэрэгцээ, шаардлага бүхий тодорхой агуулгын хүрээнд хэсэгчлэн сонголт хийж, нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийнэ. Энэ тохиолдолд ямар төрлийн мэдээ, баримт, өгөгдөлд дүн шинжилгээ хийх вэ гэсэн асуулт гарч ирэх бөгөөд агуулга, цар хүрээний хувьд сонголт хийхдээ дараах үндсэн 2 шаардлагыг хангасан байх учиртайг анхаарна уу. Үүнд:

1. Мониторингийн төлөвлөгөөнд туссан асуулга, шалгуур үзүүлэлт, арга зүйн хүрээнд байх. Өөрөөр хэлбэл менежментийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байх;
2. Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хэрэгцээ, сонирхолд нийцсэн буюу тэдний хүсэн хүлээж буй үр дүнг илэрхийлж чадахуйц, үр дүнг нотлохуйц бодит мэдээ, баримт, өгөгдлийг сонгосон байх.

Ингэснээр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад гарсан өөрчлөлтүүдийг илрүүлэн, бүхий л талуудад хүргэн нэгдсэн ойлголтыг бий болгож, улмаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, түүний үр дүнд дүгнэлт гаргах боломжийг олгоно. Энэ нь төлөвлөгөөг сайжруулах, шинэчлэх эсвэл хэвээр үлдээх гэсэн аливаа шийдвэр гаргах үндэслэл боловсруулах үйл явцыг хялбар бөгөөд бодитой болгодог.

Тухайлбал, менежментийн төлөвлөгөөнд “2018 он гэхэд хамгааллын дэглэмд хориглосон газруудад газар ашиглах зөвшөөрлийг нэмж олгоогүй байна” гэсэн зорилт дэвшүүлсэн гэж үзье. Үүний тулд:

1. Хамгаалалтын дэглэмд нийцүүлэн хориглох шаардлагатай газруудад газар ашиглах зөвшөөрөл олгосон байдлын талаар мэдээллийн сан үүсгэн тогтмол баяжуулж байх хэрэгтэй болно. Төрлийн хувьд дараах 3 мэдээллийн сан үүсэн хоорондоо холбогдсон байна.
 - Газар ашиглалттай холбоотой асуудал учраас газарзүйн мэдээллийн систем үүсгэх;
 - Товч мэдээллийг нэгтгэсэн хүснэгтэн мэдээ буюу хэн, хэзээ, ямар хүсэлт гаргасан, эсвэл дэглэмийг зөрчсөн тохиолдол гарсан эсэх, хэн хэрхэн шийдвэрлэсэн зэрэг мэдээг багтаасан байх;
 - Газар олгох эсвэл хориглох, мөн хүсэлтэд татгалзсан хариу өгсөн байдлыг ирэлхийлэх албан бичгүүдийг тусгайлан хавтас нээн хадгалсан байх.

2. Мэдээллийн сан дахь бодит мэдээ, баримт, өгөгдлийг үндэслэн тухайн дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Тухайн зорилт хэрэгжсэн эсэхээс хамааран дараах төрлийн дүгнэлтүүд гарч болно.
- *Зорилт амжилттай хэрэгжиж байгаа буюу тухайн сонгосон газар нутагт ямар нэгэн газар олгогдоогүй, дэглэм хэрэгжиж байна. Хэдийгээр энэ зорилт биелж үр дүнтэй байгаа ч хүснэгтэн болон хавтаст үүссэн мэдээллийн сангийн мэдээ, баримтад үндэслэн явцыг дүгнэн тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж дүн шинжилгээ хийх шаардлагатай. Тухайлбал, энэ хугацаанд газар ашиглах зөвшөөрөл олгох талаар хичнээн хүсэлт ирсэн, мөн тэдний зорилго ямар байсан, энэ хугацаанд ямар төрлийн зөрчил гарч хэрхэн шийдвэрлэсэн, ирээдүйд үүсэж болох бэрхшээлийн талаар таамаглал дэвшүүлэн дүнгэлт бичнэ.*
 - *Зорилтын биелэлт хангалтгүй буюу аялал жуулчлалын зориулалтаар 1 га газар олгогдсон. Нэгэнт дэвшүүлсэн зорилтодоо хүрч чадаагүй учраас мэдээллийн сангийн бодит мэдээ, баримтад үндэслэн дараах чиглэлээр нэмэлт дүгнэлт, зөвлөмж гаргах шаардлага үүснэ.*
 - o Ямар зорилгоор (хэрэгцээ, шаардлага) хаана, хэн газар олгосон?
 - o Үүнээс хамааран ямар асуудал, бэрхшээл тулгарч байна?
 - o Энэ асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэх арга замыг хэлэлцэн бичнэ.

Талуудын оролцоог хангах: Мэдээллийн сан үүсгэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг талуудад хүргэх үйл явцад хамтрагч талууд болон үр шим хүртэгчид зэрэг талуудын оролцоог хангаж байх нь чухал асуудлын нэг юм. Энэ нь:

- менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад гарч буй амжилт, сургамжийг өргөн хүрээнд болоод оновчтой тодорхойлох,
- ил тод байдлыг бий болгон улмаар үр дүнтэй хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх, хөгжүүлэх,
- талуудын хооронд үүсэж болох аливаа зөрчил, маргааныг ил тод, оновчтой шийдвэрлэх боломжийг олгох,
- хамтын оролцоотойгоор шинэлэг, бодитой, сайн, үр ашигтай шийдвэрийг гаргахад чухал ач холбогдолтой байдаг.

Ерөнхий зарчмын хувьд төлөвлөгөө боловсруулах ажлыг удирдан зохион байгуулсан багийн гишүүд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх энэ алхамд оролцох шаардлагатай боловч тухайн багт оролцоогүй судлаач, шинжээч болон бусад талуудын төлөөллийг оролцуулах нь үр дүн, үйл явцыг олон талаас харж, бодит дүн шинжилгээ хийхэд чухал нөлөөтэй. Тиймээс дээрх нөхцөлүүдийг харгалзан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг шинжлэх багт бусад

талуудын төлөөллийг оруулах нь зүйтэй. Дүн шинжилгээ хийхдээ дараах асуудлуудыг хөндөж хэлэлцэх шаардлагатай. Үүнд:

- Нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграмм, үр дүнгийн хэлхээний хүрээнд хамаарах асуудлаар гарсан үр дүнг авч үзэх;
- Одоогийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь тавьсан зорилгодоо нийцэж, түүнд хүрэх арга зам болж чадаж байгаа эсэх, стратегийн хүрээнд зорилтодоо хүрч үр дүнгээ баталгаажуулж чадсан эсэх;
- Төлөвлөгөө боловсруулах үед дэвшүүлсэн таамаглалаа эргэн харах, таамаглал үнэн зөв, бодитой байсан эсэхийг тодорхойлох;
- Мөн нөхцөл байдлын дүн шинжилгээний диаграммаа хянан үзэх, чухал хүчин зүйлүүдийг тодорхойлж чадсан байна уу?, амжилтад хүрэхэд нөлөөлөхүйц бөгөөд энэхүү диаграммд тодорхойлогдоогүй буюу хөндөгдөөгүй, явцыг нь хянах боломжгүй эсвэл чадаагүй шалтгаан, хүчин зүйл байгаа эсэхийг тодорхойлох;
- Шалгуур үзүүлэлтүүдийн хэрэглээг үнэлэх, тэднийг ашигласан уу?;
- Менежментийн төлөвлөгөөнд сонгосон хамгаалах үнэт зүйлд тулгарч буй аюул, дарамтыг бууруулах стратеги, эсвэл дам нөлөөллийг бууруулах боломж, шийдлүүдийг оновчтой тусгасан, тэдгээрийг бууруулж чадсан эсэх;
- Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтууд нь зохих түвшинд тодорхойлогдсон эсэх, мөн хугацааны хувьд тохиромжтой, хүрэх боломжтой эсэх;
- Хамгаалах үнэт зүйлийн төлөв байдал сайжирсан эсэх;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад гаргасан амжилт, сургамжаа тодорхойлж, баримтжуулсан эсэх;



- Амжилт, алдаа оноонд нөлөөлсөн хүчин зүйл юу байв;
- Асуудлыг шийдвэрлэх өөр ямар боломж байсан эсвэл байх боломжтой вэ зэрэг болно.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн шинжилгээ нь энгийн чанарын үнэлгээ байх эсвэл албан ёсны дүгнэлт байх эсэх нь ашиглаж байгаа мэдээллийн төрөл, чанараас хамаарна. Мөн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үйл явц зөв зохистой байгаа эсэхийг анхаарч хэлэлцэх нь чухал байдаг. Менежментийн төлөвлөгөөнд сонгосон хамгаалах үнэт зүйлд тулгарч буй аюул, дарамтыг бууруулах стратеги, эсвэл дам нөлөөллийг бууруулах боломж, шийдлүүдийг оновчтой тусгасан, төлөвлөсөн байж болох ч төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах баг үр дүнтэй ажиллаж чадаагүй эсвэл ажил үүргээ сайн гүйцэтгэхэд шаардагдах захиргааны болон санхүүгийн дэмжлэг байхгүй байх магадлалтай. Тиймээс дүн шинжилгээ хийхдээ мөн дараах нөхцөл, хүчин зүйлүүдийг харгалзаж үзэх нь зүйтэй. Үүнд:

- Төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хангалттай нөөц, боломж (жишээ нь, санхүүгийн, хүний, захиргааны, улс төрийн, бодлогын) байна уу? Энэ нь ямар түвшинд байна вэ?
- Төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хэрэгжилтийг хангах багийн гишүүдийн ур чадвар ямар байна вэ? Дээшилсэн үү?
- Дэд бүтэц, техник, тоног төхөөрөмж (жишээ нь, ажлын байр, машин, компьютер гэх мэт) ямар түвшинд байна вэ? Сайжирсан уу?
- Эрсдлээ хэрхэн шийдсэн бэ?
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах багийн үйл ажиллагаа хэр зэрэг явагдаж байна вэ? Эсвэл багийн үйл ажиллагаа ямар чиглэлд хэрхэн сайжирч байна вэ? (жишээ нь., багийн гишүүд хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг хариуцлага гэх мэт).

Тайлан: Эцэст нь үнэлгээний үр дүнг нэгтгэсэн дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан бичиж бүхий л талуудад заавал хүргэнэ. Энэ нь оролцогч талуудыг нэгдсэн мэдээллээр хангаж талуудын анхаарал, оролцоог нэмэгдүүлэхэд чухал нөхцөл, хөшүүрэг болдог.

Үнэлгээ, мониторингийг хэзээ хийх вэ? Энэ нь тасралтгүй буюу жил бүр явагдаж байх үйл явц бөгөөд мониторингийн төлөвлөгөөнд цаг хугацаа нь тусгагдсан байх ба дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг журмын дагуу жил бүр хамтрагч талуудын оролцоотой гаргаж үр дүнг хэлэлцэж байна.
2. Мониторингийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган тухайн жилдээ цуглуулсан мэдээ, баримт, өгөгдөлд дүн шинжилгээ хийж, жил бүр завсрын үр дүнгийн товч тайлан гаргаж байна.

3. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг 2-3 жил тутамд албан ёсоор үнэлгээний баг бүрдүүлэн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний арга зүйгээр үнэлж тайлан гаргана.
4. Шаардлагатай тохиолдолд зөвхөн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бус ерөнхий менежментийн үр дүн болон зарим тусгайлсан үнэлгээ шаардах асуудлаар хөндлөнгийн үнэлгээ захиалан хийлгэж болно. Тухайлбал, аудит, экосистемийн үйлчилгээний үнэлгээ, талуудын оролцоо, чадавхийн үнэлгээ гэх мэт. Эдгээр нь менежментийн төлөвлөгөөнд хараахан тусгаж амжаагүй асуудал, төлөвлөгөөг оновчтой боловсруулсан эсэх зэрэг орхигдол, хийдэл, алдаа оноог тодорхойлон гаргаж ирэх ач холбогдолтой.

Менежментийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Гүйцэтгэлийн тайлан иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч, тодорхой байх ёстой.

Иж бүрэн байх - бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайланд тусгагдсан асуудлуудыг зохих ёсоор нь зөв ойлгох болон тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн хэрэгцээтэй бүхий л мэдээллийг тайланд тусгасан, хавсаргасан байх.

Алдаа мадаггүй байх - тайланд тусгагдсан зүйл үнэн бодитой, зөв зүйтэй илэрхийлэгдсэн байх

Бодитой байх - тайлангийн илэрхийлэл бүхэлдээ агуулга, өнгө аясын хувьд тэнцвэрт харьцааг барьсан байхыг хэлнэ.

Итгэл үнэмшил төрүүлэхүйц байх - гүйцэтгэлийн үр дүн зорилтуудад хариулт болж чадахуйц байх, үр дүнг үнэмшилтэй илэрхийлсэн байх буюу баримтаас урган гарсан байхыг хэлнэ.

Тодорхой байх - тайланг уншиж, ойлгоход хялбар байх.

Товч байх - тайлан хэлэх гэсэн зүйлээ бусдад хүргэхээс илүү урт байх ёсгүй гэсэн үг. Хэт их дэлгэрэнгүй мэдээлэл оруулах нь тайлангийн ач холбогдлыг бууруулах, хэлэх гэсэн гол санааг далдлах, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх эрсдэлтэй.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, дэвшүүлсэн таамаглал буюу зорилго, зорилтод хийсэн дүн шинжилгээ.
- Үйл ажиллагааны болон бусад нөөц боломж, санхүүгийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ.
- Дүн шинжилгээний нэгдсэн тайлан, зөвлөмж, тэдгээрийг үндэслэн гарсан шийдвэрийн баримт.
- Менежментийн үр ашигт байдлын үнэлгээний тайлан.

4.3. ТӨЛӨВЛӨГӨӨГ САЙЖРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн бүхий л судалгаа, мониторинг, үнэлгээ, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт, санал, зөвлөмжөө түүнийг сайжруулах эсвэл бүр эрс шинэчлэх гэсэн аливаа шийдвэр гаргахдаа ашиглана. Энэ нь дасан зохицох менежментийн арга зүйн гол мөн чанар юм. Менежментийн төлөвлөгөө нь тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг нэг удаагийн үйл явц биш тул төлөвлөгөөг хэрэгжүүлж буй хугацаанд үнэлгээ, үр дүнгийн мониторинг хийж гаргасан амжилт, сургамж, хуримтлуулсан туршлага дээрээ үндэслэн үр дүнг илүү сайжруулахын тулд менежментийн төлөвлөгөө хэрэгжих хугацаа дуусаагүй байсан ч дахин сайжруулан боловсруулж болно. Дахин боловсруулах түвшин нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Үр дүнгийн тогтвортой байдлыг хангахын тулд дэвшүүлсэн таамаглал буюу зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөөг дахин хянаж хэсэгчлэн өөрчлөх шаардлагатай болдог. Ийнхүү төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийхдээ үндэслэлээ тодорхой болгон баримтжуулах шаардлагатай бөгөөд энэ нь бусад хүмүүс буюу хэрэгжүүлэгч хамтрагч талууд ямар учраас, юунд үндэслэн ямар хэмжээний өөрчлөлт хийснийг мэдэж, нэгдсэн ойлголттой байхад ач холбогдолтой.
2. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа дууссан эсвэл завсрын үр дүнгийн мониторинг, үнэлгээнд үндэслэн шаардлагатай тохиолдолд бүхий л түвшинд өөрчлөлт хийхээр бол шинэчлэн боловсруулж болно.

Өөрчлөлт хийх: Өөрчлөлтийг амжилттай хийж чадах эсэх нь дараах 4 хүчин зүйлээс хамаарна.

1. Өөрчлөгдөн буй нөхцөл байдалд дасан зохицох, шинэчлэл, өөрчлөлт хийхэд бэлэн байх, боломж, цаг хугацааг оновчтой мэдрэх;
2. Өөрчлөлт хийх хэрэгцээ, шаардлага нь маш тодорхой байх;
3. Хамтрагч болон оролцогч талуудтайгаа харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа бэхжүүлсэн байх (шаардлагатай тохиолдолд тэднийг шийдвэр гаргахад оролцуулах)
4. Өөрчлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Шинэчилсэн эсвэл сайжруулан боловсруулсан менежментийн төлөвлөгөө (энд үйл ажиллагааны төлөвлөгөө, мониторингийн төлөвлөгөө, төсөв бүгд хамаарна).
- Гаргасан шийдвэрийн баримт



ТОДОРХОЙЛОХ



ТӨЛӨВЛӨХ



ХЭРЭГЖҮҮЛЭХ



ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ,
УЯЛДУУЛАХ



ҮР ДҮНГ
ХУВААЛЦАХ





ҮР ДҮНГ ХУВААЛЦАХ

Энэ нь менежментийн төлөвлөлтийн хамгийн сүүлийн хэсэг бөгөөд дараах үйл алхамуудаас бүрдэнэ. Үүнд:

5.1 Үр дүн, амжилт, сургамж

5.2 Оролцогч талуудад мэдээлэл түгээх, солилцох

5.1. ҮР ДҮН, АМЖИЛТ, СУРГАМЖ

Менежментийн төлөвлөгөө хэрэгжиж байх явцад болон дууссаны дараа алдаа оноо, амжилт сургамжаа тодорхойлон талуудтай хуваалцана. Мөн хамтрагч талуудын сургамж, зөвлөгөөг сонсч өөрсдийн ажилтай уялдуулах нь зүйтэй. Энэ нь дараагийн шатны төлөвлөгөө боловсруулахад чухал зөвлөмж, суурь болж өгдгөөрөө ач холбогдолтой.

Дараах асуултад хариулах замаар амжилт, сургамжийг аль болох товч, тоочсон байдлаар тодорхойлж гаргана.

Амжилт:

- Менежментийн төлөвлөгөө боловсруулан ажилласны давуу тал юу байв?
- Менежментийн төлөвлөгөө боловсруулсанаар юуг сурч мэдэв?
- Ямар үр дүн гарав?

Сургамж:

- Дараа менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа юунд анхаарах хэрэгтэй вэ?
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамгийн бэрхшээлтэй хэсэг юу байв?
- Та хувь хүнийхээ хувьд юу мэдэж, ойлгож авав?

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Төлөвлөгөө хэрэгжснээр гарсан амжилт, сургамжийг тодорхойлсон байна.
- Төлөвлөгөөг эсайжруулах, дараагийн шатанд анхаарах асуудлыг тодорхойлон гаргасан байна.

5.2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, СОЛИЛЦОХ

Мэдээлэл солилцох нь хамгийн чухал үйл явц билээ. Ингэснээр ажлаа уялдаатай байлгах, мөн ямар ажлыг орхигдуулж буйгаа мэдэх, юунд цаашид анхаарах хэрэгтэйг талуудад анхааруулж, сануулж байх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг олон сайн талтай.

Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, явцын байдал, амжилт, сургамжаа хамтран ажиллаж буй талуудтайгаа хуваалцах олон арга зам байна. Үүнийгээ албан ёсны болгож, талуудад мэдээллээ солилцох хэлбэрээ сонгон төлөвлөгөөндөө тусган ажиллах нь зүйтэй. Үүнд:

- Үр дүнгээ нэгтгэсэн тайлан хэвлэх. Энэ нь амжилт, сургамжаа зөвхөн хамтрагч талуудад биш бусад сонирхогч талуудад хүргэх, хуваалцах боломж юм.
- Товч тайлан гарган бичгээр хүргүүлэх.
- Цахим орчинд дотоод сүлжээ байгуулан мэдээллээ түгээх, солилцох.
- Менежментийн төлөвлөгөө боловсруулах үед ямар байсан хэрэгжүүлж дууссаны дараа ямар асуудлыг хэрхэн шийдсэн талаар кино, шторк хийх, түгээх. Энэ нь ижил чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүстэй туршлагаа хуваалцах боломжийг олгоно.
- Өдөрлөг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг болно.

Эдгээр үйл ажиллагаанууд нь зөвхөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээд дууссаны дараа биш төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэг бүхий л үе шатанд хамт хэрэгжиж байх ёстой.

ЭНЭ АЛХАМД ГАРАХ ҮР ДҮН:

- Мэдээлэл хүргэх гол оролцогч талууд тодорхой болно.
- Талуудтай харилцах арга зам тодорхой болсон байна.
- Мэдээлэл, тайлан, үр дүнгийн бүтээгдэхүүнүүд бэлэн болсон байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- БОАЖЯ. (2018). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний арга зүй.
- БОНХЯ. (2012). Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж. НҮБХХ.
- Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоол. Түүнийг дагаж гарсан Аргачлал, загвар батлах тухай ЗГХЭГ-ын даргын 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаал. <https://cabinet.gov.mn/>
- Conservation Measures Partnership. (2013). CMP Open Standard Version 3.0.
- Conservation Measures Partnership. (2020). CMP Open Standard Version 4.0.
- FOS. (2009). Conceptualizing and Planning Conservation Projects and Programs: A Training Manual. Foundations of Success, Bethesda, Maryland, USA. (November), 160.
- Miradi. (n.d.). HANDS-ON MIRADI EXERCISES Getting Started HANDSON MIRADI EXERCISES Lessons included in this hands-on tutorial. <https://www.miradi.org/>, 1–48.
- Stewart, A., & Scholarship, F. (2016). Open Standards and Collective Impact.
- TNC. (2007). Conservation Action Planning Handbook. Work, 127. <https://doi.org/10.1016/j.physbeh.2016.04.005>
- TNC. (2017). Нутгийн иргэдийн байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан зөвлөмж.
- USAID. (2016). Using Results Chains to Depict Theories of Change in USAID Biodiversity Programming.
- WWF. (2017). WWF Standards of Conservation Project and Programme Management (PPMS).
- WWF. (2011). Climate Adaptation: Mainstreaming in Existing Conservation Plans.
- WWF. (2017). PPMS. Gender and Diversity—short version.

ХАВСРАЛТ 1. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

Менежментийн төлөвлөгөөнд нэгдсэн стандарт, хэлбэр байдаггүй. Харин агуулга болон бүтэц нь үргэлж тухайн ТХГН-ийн хэрэгцээ, шаардлага, зорилго, үйл ажиллагаа, хэрэгжүүлэгчдийн үүрэг, хариуцлага, тэдний нөөц бололцоог нэгтгэж багцалсан байдаг.

Менежментийн төлөвлөгөө нь дараах ерөнхий агуулга, бүтцийн хүрээнд бичигдэж болно.

Хураангуй дүгнэлт: Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан гол асуудлууд, тэдгээрийн шийдлүүдийг нэгтгэсэн дүгнэлтийг энэ хэсэгт бичнэ. Сонирхогч талууд төлөвлөгөөг бүхэлд нь унших шаардлагагүй, эсвэл боломжгүй тохиолдолд энэ хэсэгт гол анхаарал хандуулдаг. Ийм учраас тухайн менежментийн төлөвлөгөөний гол асуудлыг хураангуйлсан товч мэдээлэл байх ёстой.

Оршил: Менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, гол зорилго, менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл, баримталсан зарчмууд, хэрэглэсэн арга зүй болон төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн талаарх товч мэдээлэл, төлөвлөлтийн үйл явц, оролцсон байгууллага, хүмүүсийн талаарх мэдээллийг товчлон оруулна.

ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө:

1. Алсын хараа
2. Хамрах хүрээ
3. Хамгаалах үнэт зүйл, сонгосон үндэслэл
 - 3.1 Төлөв байдлын үнэлгээ
 - 3.2 Аюул, дарамт, түүний үнэлгээ
4. Нөхцөл байдлын дүн шинжилгээ
5. Стратеги, зорилт
6. Үйл ажиллагааны төлөвлөгөө
 - 6.1 Мониторингийн төлөвлөгөө
7. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх механизм: Энд талуудын оролцоо, хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавхи, санхүүжилтийн нөөц боломж, техник хэрэгсэл, хангамжийн чадамж, учирч болзошгүй эрсдлийн талаар тоймлон оруулна (Төлөвлөгөөг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хамтаар жил бүр нарийвчилан гаргана).
 - Ашигласан бүтээл
 - Хавсралт

ХАВСРАЛТ 2. ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

<https://cabinet.gov.mn/4523.html>
[http://www.ccnetglobal.com/coach-resources/all-resources/
www.panda.org/standards](http://www.ccnetglobal.com/coach-resources/all-resources/www.panda.org/standards)
<https://sites.google.com/a/wwf.panda.org/ppms/>
<http://cmp-openstandards.org/>
[http://www.fosonline.org/resources.](http://www.fosonline.org/resources)
[https://www.conservationgateway.org/ConservationPlanning/
ActionPlanning/Pages/conservation-action-plann.aspx](https://www.conservationgateway.org/ConservationPlanning/ActionPlanning/Pages/conservation-action-plann.aspx)
<http://www.conservationmeasures.org/>
<https://www.miradi.org/>
<https://www.conservationgateway.org/Pages/default.aspx>



